




М

ОНГОЛБАНКНЫ ЭДЭЭЛЭЛ



Монголбанкны үндсэн зорилт нь үндэсний мөнгөн тэмдэгт - төгрөгийн тогтвортой байдлыг хангахад оршино.

2018 • XII • № 26



МОНГОЛБАНКНЫ 2018 ОНЫ ОНЦЛОХ 18 ҮЙЛ ЯВДАЛ

**Н.БАТСАЙХАН:
ЭРСДЭЛЭЭС
СЭРГИЙЛСЭН
БАНКНЫ ХЯНАЛТ
ШАЛГАЛТЫГ
ДЭЛХИЙ НИЙТЭЭР
МӨРДӨЖ БАЙНА**

ЭРДЭНЭСИЙН САНГИЙН ҮЗМЭРЭЭС: АЛТАН НАВЧИТ ӨРГӨМЖЛӨЛ

Монголбанкны Олон нийтийн боловсрол, мэдээллийн төвөөс эрхлэн гаргав.

Мэндчилгээ:Монголбанкны Ерөнхийлөгч
Н.Баяртсайхан

ХУУДАС

3

**2018 оны онцлох
18 үйл явдал:**

“Банк санхүүгийн салбарын хууль эрх зүйн шинэтгэлийн хөтөлбөр”-ийн хүрээнд 2018 оныг банк санхүүгийн салбарын шинэчлэлийн жил болгон зарлаж, бодлогын тодорхой зорилтуудыг дэвшүүлэн хэрэгжүүллээ.

ХУУДАС

4

Байр суурь:

Санхүүгийн зах зээлийн тогтвортой байдал 2018 онд

ХУУДАС

10

Нийтлэл:

Эрсдэлээс сэргийлсэн банкны хяналт шалгалтыг дэлхий нийтээр мөрдөж байна

ХУУДАС

12

**Мөнгөн тэмдэгтийн
түүх:**

5000 төгрөгийн дэвсгэртийн хамгаалалтын таних тэмдгүүд

ХУУДАС

16

Судалгаа:

Эдийн засаг өсөлттэй байгаа ч анхаарах асуудлууд байсаар байна...

ХУУДАС

17

**Монголбанкны
Эрдэнэсийн сангаас:**Богд хаанд өргөсөн
алтан навчит өргөмжлөл

ХУУДАС

23

**Монголбанк
юу хийдэг вэ?**

Б.Хүслэн: Төв банкны судалгаа нь макро эдийн засаг, санхүүгийн тогтвортой байдлыг хангахад бодлогын томоохон дэмжлэг болдог

ХУУДАС

24

Асуулт, хариулт:

Монголбанкны хэвлэлийн бага хурлаас (2018.12.14)

ХУУДАС

29

Ярилцлага:

Б.Даваадалай: Эдийн засаг эргээд хүндрэлд орох магадлал маш ойрхон гэдгийг санах хэрэгтэй

ХУУДАС

34

Дэлхийн эдийн засаг:

Пол волкерийн өв

ХУУДАС

39

Санхүүгийн боловсрол:

Инфляци гэж юу вэ?

ХУУДАС

42



Мэндчилгээ

Эрхэм хүндэт Та бүхэнд айлчлан ирж буй 2019 онд эрүүл энх, эрч хүчтэй, ирмүүн их амжилтаар дүүрэн байхыг хүсэн ерөөж, Шинэ жилийн мэнд дэвшүүлье!

2018 он эдийн засгийн сэргэлт үргэлжлэхийн зэрэгцээ банк санхүүгийн секторт шинэчлэл хийгдсэн реформын жил боллоо. Монголбанк үндсэн зорилтынхоо хүрээнд дунд хугацааны үнийн тогтвортой байдлыг хадгалж, инфляцийн дарамтгүй эдийн засгийн өсөлтөд дэмжлэг үзүүлэхэд чиглэсэн мөнгөний бодлогыг хэрэгжүүлээ. Үр дүнд нь иргэд аж ахуйн нэгжүүдийн санхүүжилтийн өртөг буурч, бизнесийн зээл олголт нэмэгдэн, хувийн хөрөнгө оруулалт идэвхжсэн бөгөөд энэ нь эдийн засагт бий болсон эерэг үр дүнг бэхжүүлэхэд чухал алхам байв. Эдийн засгийн гадаад орчны харьцангуй таатай байдал үргэлжилсэн энэ цаг үед бодлогын сахилга бат хадгалагдаж, хөрөнгө оруулагчдын итгэл дээшилж, улсын зээлжих зэрэглэл ч өсөв. Түүнчлэн, банкны салбарын тулгуур хуулиуд болох Төв банкны тухай хууль, Банкны тухай хууль тэргүүтэй эрх зүйн цогц шинэчлэл хийгдэж эхэлсэн нь 2018 оны гол онцлог байлаа. Төв банк сайн засаглалын элементүүдийг нэвтрүүлэн Мөнгөний бодлогын хороогоор бодлогын шийдвэрийг хамтын зарчмаар гаргадаг болсны зэрэгцээ макро зохистой бодлогыг хэрэгжүүлэх шинэ чиг үүрэгтэй болов. Ингэснээр мөнгөний бодлогын үр нөлөөг дээшлүүлэх, санхүүгийн секторт эрсдэл хуримтлагдахаас сэргийлэх боломж дээшилж байна.

Мөн эрсдэлд суурилсан хяналт шалгалтын тогтолцоог нэвтрүүлэх эхлэл тавигдлаа. Ингэснээр бодит секторт хэрэгцээт санхүүжилтийг нийлүүлдэг банкны систем илүү эрүүл байж, санхүүгийн зуучлал хэвийн үргэлжилж, эдийн засаг илүү тогтвортой байна гэдэг итгэлийг хадгалахад чухал алхам болов. Валютын нөөцийг үргэлжлүүлэн нэмэгдүүлсэн нь төгрөгт итгэх итгэлийг хадгалах, цаашид хүлээгдэж буй эдийн засгийн эрсдэлүүдийг даван туулахад чухал байх болно. Хэдийгээр эдийн засгийн сэргэлт, гадаад болон дотоод зарим шокоос үүдэлтэй төлбөрийн тэнцэл дээрх дарамт нь оны хоёрдугаар хагаст төгрөгийн ханшийг сулруулах нөлөө үзүүлсэн ч, Монголбанк валютын зах дээрх оролцоо болон мөнгөний бодлогын арга хэрэгслээр эрэлт нийлүүлэлтийн зөрүүнээс үүдэлтэй богино хугацааны огцом савлагааг зах зээлд үүсэхээс сэргийлж ажилласнаар оны эцэст төгрөгийн ханш тогтворжиж байна. 2018 оныг дүгнэхэд, эдийн засагт тулгарч байсан олон сорилтуудыг амжилттай даван туулж, эдийн засгийн сэргэлтийг үргэлжлүүлсэн амжилттай жил байв. Ирэх 2019 оны хувьд Төв банкны бодлого нь эдийн засгийн болон санхүүгийн системийн тогтвортой байдлыг улам бэхжүүлж, санхүүгийн зах зээлийн хөгжлийг хөтлөхөд чиглэх болно.

Монгол улсын минь, түмэн олны минь заяа
тэгш дүүрэн байх болтугай!


МОНГОЛБАНКНЫ ЕРӨНХИЙЛӨГЧ

Н.БАЯРТСАЙХАН

МОНГОЛБАНКНЫ 2018 ОНЫ

“БАНК САНХҮҮГИЙН САЛБАРЫН ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ШИНЭТГЭЛИЙН ХӨТӨЛБӨР”-ИЙН ХҮРЭЭНД 2018 ОНЫГ БАНК САНХҮҮГИЙН САЛБАРЫН ШИНЭЧЛЭЛИЙН ЖИЛ БОЛГОН ЗАРЛАЖ, БОДЛОГЫН ТОДОРХОЙ ЗОРИЛТУУДЫГ ДЭВШҮҮЛЭН ХЭРЭГЖҮҮЛЛЭЭ.

УИХ-аас баталсан “Эдийн засгийг сэргээх хөтөлбөр”-т туссан Монгол Улсын санхүүгийн тогтвортой байдлыг бэхжүүлэх, эдийн засгийн хүндрэл бэрхшээлийг даван туулах, эдийн засгийн өсөлтийг дэмжих хууль, эрх зүйн орчныг бүрдүүлэх шаардлагын дагуу Монголбанкны Ерөнхийлөгчийн тушаалаар “Банкны салбарын хууль эрх зүйн шинэтгэлийн хөтөлбөр”-ийг баталлаа. Нийт 10 гаруй хуулийн төсөл боловсруулсны дотор 2018 онд “Төв банкны тухай хууль”, “Банкны тухай хууль”, “Банкны салбарын тогтвортой байдлыг хангах тухай хууль”, “Банкин дахь мөнгөн хадгаламжийн даатгалын тухай хууль”, “Мөнгө угаах болон терроризмтэй тэмцэх тухай хууль”-д нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийг УИХ-аар батлуулан “Активын удирдлагын компанийн тухай хууль”, “Валютын зохицуулалтын тухай хууль”-ийн төслийг боловсруулан хууль санаачлагчид уламжилж, УИХ-д өргөн мэдүүлээд байна.



Банк санхүүгийн салбарын харилцагчдын эрх ашгийг хамгаалах хууль эрх зүйн орчныг бүрдүүлэх, олон нийтийн эдийн засаг, санхүүгийн мэдлэгийг дэмжих зорилгоор “Санхүүгийн хэрэглэгчийн эрхийг хамгаалах аян”, “Эх орныхоо алтыг Эрдэнэсийн сандаа”, “Санхүүгийн боловсролын аян”, “Цахим эринд-Цахим төлбөр тооцоо” аяныг зохион байгуулсны үндсэнд “Санхүүгийн хэрэглэгчийн эрхийг хамгаалах” хуулийн төслийг бэлэн болгов.



өмнөх түвшнээс 2.2 нэгж хувиар буурлаа. Ийнхүү зээлийн хүү буурахын зэрэгцээ 2014 оноос зогсонги байдалд орсон бизнесийн зээл сэргэж, III улирлын эцсийн байдлаар жилийн өмнөх түвшнээс 13 хувиар өсөөд байна. Ирээдүйд чиглэсэн мөнгөний бодлогын шийдвэр, түүнийг дагасан зээлийн өсөлт, хүүний бууралт нь хувийн хөрөнгө оруулалт болон эдийн засгийн өсөлт, ажил эрхлэлтэд түлхэц өгч байна.

Инфляцийг 8 хувийн орчимд тогтворжуулах мөнгөний бодлогын шийдвэрүүд нь банкны салбарын зээлийн нийлүүлэлт, хүүний өрсөлдөөнийг нэмэгдүүлснээр шинээр олгосон зээлийн хүү 2018 оны III улирлын байдлаар 17.7 хувь болж, жилийн

ИНФЛЯЦИЙН ЗОРИЛТОД НИЙЦТЭЙ, ЗАХ ЗЭЭЛИЙН ЗАРЧИМД СУУРИЛСАН МӨНГӨНИЙ БОДЛОГЫН ҮР ДҮНД САНХҮҮЖИЛТИЙН ӨРТӨГ БУУРЧ, ЭДИЙН ЗАСГИЙН САЛБАРУУДЫН ӨСӨЛТ ЖИГДЭРЛЭЭ.

МОНГОЛБАНК ОЛОН УЛСЫН ЖИШГИЙГ БАРИМТЛАН МӨНГӨНИЙ БОДЛОГО, БАНКНЫ ХЯНАЛТ ШАЛГАЛТАЙ ХОЛБООТОЙ АЛИВАА ШИЙДВЭРИЙГ ХАМТЫН УДИРДЛАГЫН ЗАРЧИМД ТУЛГУУРЛАН ГАРГАДАГ БОЛОВ.

Мөнгөний бодлогын шийдвэрийг Монголбанкны Ерөнхийлөгчийн давуу эрхтэй саналаар гаргадаг байсныг өөрчлөн, Мөнгөний бодлогын хороон дээр хэлэлцэн шийдэх хамтын удирдлагын зарчимд шилжүүлэв. Шийдвэр гаргалтад олон талын мэдээлэлд тулгуурлаж, хараат бус гишүүдийн оролцоог тэгш хангах бололцоог бий болгосноор хяналтын зохистой тогтолцоо бүрдэж, мөнгөний бодлогын шийдвэрт олон нийтийн итгэх итгэлийг дээшлүүлэхэд чухал алхам болов. Мөн банкны хяналт шалгалттай холбоотой аливаа шийдвэрийг хамтын зарчмаар шийдвэрлэдэг байхаар Монголбанкны бүтцэд “Хяналт шалгалтын хороо”-г байгуулав.



эрсдэлтэй валютын зээлийн эрсдэлийн жинг 150% болгон нэмэгдүүлэх макро зохистой бодлого боловсруулж, зохиц хэрэгслүүдийг ашиглаж эхлэв.

Монголбанк макро зохистой бодлогыг хэрэгжүүлэх хуулийн мандат, түүнийг хэрэгжүүлэх стратегитай болов. Ингэснээр мөнгөний бодлогын үр нөлөөг дээшлүүлэх, санхүүгийн системд эрсдэл хуримтлагдахаас сэргийлэх, макро тогтвортой байдлыг хангах боломжийг дээшлүүлэхэд том ахиц дэвшил гарлаа. Макро зохистой бодлогыг хэрэгжүүлэх явцад хэрэглээний зээлийн өр, орлогын харьцааны дээд хязгаарыг 70 хувиар тогтоон мөрдүүлэх, хугацааг 30 сараас хэтрүүлэхгүй байх, ААН-д олгосон ханшийн

4. МОНГОЛБАНК МАКРО ЗОХИСТОЙ БОДЛОГО ХЭРЭГЖҮҮЛДЭГ ТӨВ БАНК БОЛОВ.

ОНЦЛОХ 18 ҮЙЛ ЯВДАЛ

**БАНКНЫ САЛБАРТ
ОЛОН УЛСЫН
СТАНДАРТЫН ДАГУУ
АЗИД АНХ УДАА
АКТИВЫН ЧАНАРЫН
ИЖ БҮРЭН ҮНЭЛГЭЭГ
ОЛОН УЛСЫН
ХӨНДЛӨНГИЙН
АУДИТЫН КОМПАНИАР
ХИЙЛГЭВ.**

ОУВС-ийн “Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр”-ийн хүрээнд Монгол Улс Ази тивд активын чанарын иж бүрэн үнэлгээ хийсэн анхны улс болов. Активын чанарын үнэлгээний үр дүнд банкны системийн хэмжээнд өөрийн хөрөнгийн дутагдал 2017 оны жилийн эцсийн ДНБ-д харьцуулахад 1.9 хувьтай тэнцэхүйц хэмжээтэй гарсан нь Монголбанкнаас урьдчилан таамаглаж байсан хэмжээтэй дүйцэв. Цаашид өөрийн хөрөнгийг нэмэгдүүлэх үүрэг даалгаврыг банкуудад өгч, тухайн шаардлагыг 2018 оны 12-р сард багтаан ханган биелүүлэхээр ажиллаж байна.



хөрөнгөөс хүлээж болзошгүй алдагдлыг урьдчилан харж тооцоолон, түүнд тохирсон эрсдэлийн нөөц санг байгуулж, бодит эрсдэл учирсан тохиолдолд эрсдэлийг зохистой удирдах боломжтой болов.

Монголбанк 2018 оноос дэлхий даяар хүчин төгөлдөр мөрдөж буй олон улсын нягтлан бодох бүртгэлийн шинэ стандартын дагуу санхүүгийнхээ тайланг гаргаж, Төв банкны бодлогын найдвартай, хариуцлагатай байдлыг бататгалаа. Мөн Санхүүгийн тайлагналын олон улсын IX стандартын дагуу санхүүгийн хөрөнгийн хүлээж болзошгүй алдагдлын хэмжээг урьдчилан тооцоолох аргачлалыг шинээр боловсруулж, “Санхүүгийн хөрөнгийн эрсдэлийн үнэлгээний заавар”-ыг баталснаар тухайн санхүүгийн

**НЯГТЛАН БОДОХ
БҮРТГЭЛИЙН
ОЛОН УЛСЫН
IX СТАНДАРТЫГ
2018 ОНД
НЭВТРҮҮЛЭН
ХЭРЭГЖҮҮЛЖ
ЭХЭЛЛЭЭ.**

**МОНГОЛ УЛСЫН
УРТ ХУГАЦААНЫ
ЗЭЭЛЖИХ ЗЭРЭГЛЭЛ
НЭМЭГДЭЖ, ХӨРӨНГӨ
ОРУУЛАГЧДЫН
ИТГЭЛИЙГ
СЭРГЭЭХИЙН ТУЛД
ЗАСГИЙН ГАЗАРТАЙ
ХАМТРАН АЖИЛЛАВ.**

Монгол Улсын Засгийн газартай хамтран Монгол Улсын зээлжих зэрэглэлийг сайжруулах чиглэлээр зэрэглэл тогтоогч компаниудыг мэдээллээр бүрэн хангаж, хамтран ажилласнаар Олон Улсын зээлжих зэрэглэл тогтоодог Фитч болон Стандарт энд Пүүрс агентлагаас манай улсын урт хугацааны зээлжих зэрэглэлийг дээшлүүлээ. Фитч агентлаг манай улсын урт хугацааны зээлжих зэрэглэлийн үнэлгээг “B-” байсныг “B” болгон дээшлүүлж, төлөвийг “Тогтвортой” болгосон бол Стандарт энд Пүүрс агентлаг мөн урт хугацааны зээлжих зэрэглэлийн үнэлгээг “B-” байсныг “B” болгон дээшлүүлж, төлөвийг “Тогтвортой” хэвээр хадгалав. Ингэснээр төрийн болон хувийн хэвшилд хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх бололцоо бүрдэж, төсөв, мөнгөний арга хэмжээнүүд дунд, урт хугацааны тогтвортой байдлыг хангахад чиглэж байна.

Огноо	Moody's		Fitch		S&P	
	Үнэлгээ	Төлөв	Үнэлгээ	Төлөв	Үнэлгээ	Төлөв
I/18	B3	▲				
2018 IV/20		●				
VII/9			B	▲	B-	●
XI/9					B	▲

Зэрэглэлийн өөрчлөлт ▲ ▼
Төлөв: (●)-эсрэг, (▲)-тогтвортой, (-)-сөрөг



орлуулах, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, ажиллах хүчний бүтээмжийг дээшлүүлэх, эдийн засгийг олон тулгуурт, өрсөлдөх чадвартай болгох бодлогын болон бүтцийн реформуудыг хийх нь эдийн засгийн хүндрэлийг гэтлэн давж, цаашдын тогтвортой хөгжилд хүргэх чухал болохыг оролцогчид санал нэгтгэж дүгнэв. 2019 оны “Эдийн засгийн бодлогын чуулган”-ыг Монгол Улсад банкны салбар үүсгэж хөгжсөний 95 жилийн ойн нэрэмжит эрдэм шинжилгээний хуралтай нэгтгэн Улаанбаатар хотод ирэх 4-р сард зохион байгуулахаар бэлтгэл ажлыг хангаж байна.

**ЭДИЙН ЗАСГИЙН
БОДЛОГЫН ДЭЭД
ХЭМЖЭЭНИЙ
ЧУУЛГАНЫГ
САНААЧЛАН “ЭДИЙН
ЗАСГИЙН БОДЛОГЫН
СОРИЛТ, ЧИГ
ХАНДЛАГА” СЭДВИЙН
ДОР АМЖИЛТТАЙ
ЗОХИОН БАЙГУУЛЛАА.**

МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСГИЙН УРТ ХУГАЦААНЫ БОДЛОГО БОЛОВСРУУЛАХ, ШИЙДВЭР ГАРГАХАД ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЭХ ЗОРИЛГООР ЭДИЙН ЗАСГИЙН СУДАЛГАА, СУРГАЛТЫН ХҮРЭЭЛЭН (ЭЗССХ)-Г ШИНЭЭР БАЙГУУЛЛАА.

Дэлхийн төв банкуудын шилдэг туршлага, жишгийн дагуу Монголбанк ЭЗССХ-г шинээр үүсгэн байгуулав. ЭЗССХ –г төв банкны үндсэн чиг үүргээс гадна төсвийн бодлого, санхүүгийн зах зээл, эдийн засгийн өсөлт, нийгмийн хөгжил, улс орны эдийн засгийн түүх, хүн ам зүй, хөдөлмөрийн зах зээл, аж үйлдвэрлэл, хууль ба эдийн засаг, эрүүл мэнд, боловсрол, баялаг, бус нутгийн эдийн засаг, ХАА, байгалийн баялаг зэрэг чиглэлээр бодлогын судалгааны ажил, стратегийн баримт бичиг, тодорхой асуудлаар зөвлөмж гаргах, эдийн засаг, санхүүгийн чиглэлийн мэргэжлийн сургалт, уулзалт, хэлэлцүүлэг, хурал зохион байгуулах чиг үүрэгтэйгээр байгуулсан юм. ЭЗССХ-ийн ажиллах хэлбэр, дунд хугацаанд гүйцэтгэх бодлогын судалгааны ажлын төлөвлөгөөг олон улсын туршлагад тулгуурлан боловсруулж, үйл ажиллагааг нь зүгшрүүлэв. Ингэснээр макро эдийн засгийн өргөн хүрээний асуудлыг хамарсан, судалгаанд суурилсан бодлогын зөвлөмжүүдийг гарган УИХ, Засгийн газар болон төрийн бусад байгууллагад хүргүүлэх, төрийн албан хаагчид болон санхүүгийн салбарын мэргэжилтнүүдэд зориулсан дунд болон ахисан түвшний сургалт явуулах боломж, чадамж бүрдэв.



Үндэсний цахим гүйлгээний төвийн системээр дамжуулан хийх банк хоорондын бага дүнтэй гүйлгээний дээд хязгаар 1 сая төгрөг байсныг нэмэгдүүлж 3 сая төгрөг болгон шинэчлэн тогтоолоо. Мөн Үндэсний төлбөрийн ₮ картын соронзон туузыг олон улсын стандартын дагуу чип болон зайнаас унших технологид шилжүүлэх ажлыг эхлүүлснээр төлбөрийн картын нууцлал, аюулгүй байдлыг сайжруулах, шинэ дэвшилт төлбөрийн үйлчилгээг нэмэгдүүлэх боломж бүрдэж байна. Гүйлгээ дамжуулах

хурдыг гурав дахин нэмэгдүүлж, системийн тасралтгүй, найдвартай байдлыг улам бүр хангах, төгрөгтэй адилтгах бэлэн бус төлбөрийн хэрэгсэлд анхны тусгай зөвшөөрлийг олгож, санхүүгийн байгууллагад зориулж, цахим орчинд дамжуулах баримт бичгийн бүрэн бүтэн байдал, үнэн зөвийг баталгаажуулах дижитал технологийг нэвтрүүлэх зэргээр олон улсын төлбөрийн системийн хөгжил дэвшилтэй эн зэрэгцэн алхахыг эрмэлзэж байна.

ҮНДЭСНИЙ ТӨЛБӨРИЙН СИСТЕМ ИЙН ЭРХ ЗҮЙН ОРЧНЫГ БҮРДҮҮЛЖ, ОРЧИН ҮЕИЙН ТӨЛБӨРИЙН ХЭРЭГСЛИЙН ШИНЭ ТЕХНОЛОГИЙГ ДЭМЖИН ХЭРЭГЖҮҮЛЛЭЭ.

МОНГОЛ УЛСЫГ ТОГТВОРТОЙ ӨСӨЛТ, ХӨГЖИЛД ХҮРГЭХ СУУРЬ БОДЛОГЫН ТУНХАГ БҮХИЙ "УЛААНБААТАРЫН ЗӨВШИЛЦӨЛ" НАЙМАН ЗАРЧМЫГ САНААЧИЛЖ ОЛОН НИЙТЭЭР ХЭЛЭЛЦҮҮЛЭН ТОДОРХОЙЛОВ.

Монголбанкнаас хийж гүйцэтгэсэн цаг үеийн тулгамдсан асуудлаарх бодлогын шинж чанартай судалгааны ажлуудын үр дүнг тухай бүр олон нийтэд танилцуулах, эрдэмтэн судлаачдын санал шүүмжийг авч тусгах хурал хэлэлцүүлгийг өргөн хүрээнд зохион байгуулж хэвшүүлээ. Түүнчлэн, хурал, хэлэлцүүлгээр хөндөн ярьсан сэдвийн агуулга, оролцогчдын санал, шүүмжийг нэгтгэн хурлын материалын хураангуйг боловсруулан, бодлогын шийдвэр гаргагчид, олон нийтэд танилцуулах шинэ арга, хэлбэрт шилжлээ. Эдгээрийн нэг нь Монголбанкны Ерөнхийлөгчийн санаачилсан эдийн засгийн тогтвортой өсөлт, хөгжлийг хангахад чиглэсэн "Улаанбаатарын зөвшилцөл" юм. Дэлхийн улс орнууд нийтээр хүлээн зөвшөөрсөн хэм хэмжээ, бодлогын зорилт, тунхаглалыг "Бодлогын зөвшилцөл" болгон гаргадаг. Энэ жишгийн дагуу "Улаанбаатарын зөвшилцөл" – өөр Монгол Улсыг тогтвортой өсөлт, хөгжилд хүргэх найман зарчмыг тунхаглахыг зорив. Олон талын төлөөллийг оролцуулсан нээлттэй хэлэлцүүлгийн үеэр төрийн аливаа шийдвэрт баримтлах суурь зарчим, тунхаглалыг буй болгох нь зүйтэй гэдэгт эрдэмтэн, судлаачид санал нэгдэж, энэхүү бодлогын суурь тунхаг зарчмыг сайшаан дэмжив.



**“ЗЭЭЛИЙН ХҮҮГ
БУУРУУЛАХ СТРАТЕГИ
2018–2023” БОЛОН
ТҮҮНИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ
ТӨЛӨВЛӨГӨӨ ЗЭРЭГ
ЦОГЦ БАРИМТ
БИЧГИЙГ САНХҮҮГИЙН
ТОГТВОРТОЙ БАЙДЛЫН
ЗӨВЛӨЛӨӨР БАТЛУУЛЖ,
ХЭРЭГЖҮҮЛЖ
ЭХЭЛЛЭЭ.**

Төрөөс мөнгөний бодлогын талаар 2018 онд баримтлах үндсэн чиглэлийг баталсан УИХ-ын тогтоолыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд олон талын төлөөллийг оруулсан “Зээлийн хүүг бууруулах стратеги боловсруулах” үүрэг бүхий ажлын хэсгийг Монголбанкны Ерөнхийлөгчийн тушаалаар байгуулж, 6 сарын хугацаанд ажиллуулж төслийг бэлтгэв. Энэ хүрээнд судалгаа, шинжилгээний үр дүнд тулгуурласан, олон талт байгууллагуудын хамтын ажиллагааг шаардсан цогц стратеги бүхий “Зээлийн хүүг бууруулах стратеги 2018–2023” төслийг боловсруулсан нь үндэсний хэмжээний зөвшилцөлд тулгуурласан цогц баримт бичиг болов. Энэхүү стратегийг батлуулснаар бодлого боловсруулагчид болон олон нийтэд зээлийн хүүтэй холбоотой асуудлаарх Монголбанк, Засгийн газрын байр суурийг маш тодорхой илэрхийллээ. Монголбанкнаас уг стратегид тусгасан ажлыг тухайлбал, инфляцийн зорилтыг хангахад сөрөг нөлөөгүйгээр бодлогын хүүг бууруулах, төв банкаас 90 хоног хүртэлх хугацаатай санхүүжилт олгох байнгын хэрэгсэл нэвтрүүлэх, макро зохистой бодлогын арга хэмжээ зэргийг оны турш цаг алдалгүй хэрэгжүүлснээр банкуудын төгрөгийн хадгаламжийн жигнэсэн дундаж хүү 11.7 хувь, төгрөгийн зээлийн жигнэсэн дундаж хүү 17.6 хувь болж буураад байна.



тодорхойлолтуудыг олон улсын стандартад нийцүүлэх, хууль зөрчигчдөд хүлээлгэх хариуцлагыг эрс чангатгах талаар хийж буй ажлыг үнэлэв.

FATF-ын Ази, Номхон далайн бүс нутаг хариуцсан бүлэг /APG-ийн жилийн уулзалт 2018 оны 7-р сарын 21–27 –ны өдөр болж, энэ үеэр Монгол Улсын авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний үрд дүнг хэлэлцэв. Монгол Улс мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцоогоо FATF-ын зөвлөмжид нийцүүлж, хуулийн үйлчлэх хүрээг өргөжүүлэх, хяналт шалгалтыг эрсдэлд суурилсан хэлбэрт шилжүүлэх, харилцагчийг таньж мэдэх үйл ажиллагааг эрсдэлд суурилан гүйцэтгэх, хуулийн нэр томъёоны

**МОНГОЛ УЛС МӨНГӨ
УГААХ БОЛОН
ТЕРРОРИЗМЫГ
САНХҮҮЖҮҮЛЭХТЭЙ
ТЭМЦЭХ ҮЙЛ
АЖИЛЛАГААГАА
ЭРЧИМЖҮҮЛЖ,
“СААРАЛ
ЖАГСААЛТ”-Д ОРОХ
ЭРСДЭЛЭЭС ГАРЧ,
ЭРЧИМТЭЙ ХЯНАЛТАД
ШИЛЖЛЭЭ.**

**ГАДААД ВАЛЮТЫН
УЛСЫН НӨӨЦИЙГ
НЭМЭГДҮҮЛЭХ
ЗОРИЛГООР АЛТ
ХУДАЛДАН АВАХ
АЖИЛЛАГААГ ОРОН
НУТАГТ ОЙРТУУЛЖ,
АЛТ ТУШААГЧДАД
ТУЛГАРДАГ ХҮНДРЭЛ
БЭРХШЭЭЛИЙГ
ХӨНГӨВЧИЛЛӨӨ.**

Гадаад валютын улсын нөөцийг бүрдүүлдэг гол эх үүсвэр болох Монголбанкны алт худалдан авалтын хэмжээг нэмэгдүүлэх зорилгоор Монголбанкнаас “Эх орныхоо алтыг Эрдэнэсийн сандаа” аяныг зохион байгуулж, аяны хүрээнд Швейцарийн Хөгжлийн агентлаг, Стандарт хэмжил зүйн газартай хамтран Дархан–Уул, Баянхонгор аймагт олон улсын стандарт, шаардлагыг хангасан орчин үеийн үнэт металлын сорьц тогтоох лаборатори байгууллаа. Ийнхүү Монголбанкны алт худалдан авалтын талаар олон нийтэд чиглэсэн ажлыг эрчимжүүлж, орон нутагт албан ёсоор алт худалдах боломжийг анх удаа бүрдүүлж өгснөөр Монголбанкны худалдан авсан алтны хэмжээ 2018 онд 21 тонныг давж, өмнөх оныхоос нэмэгдлээ.



түүнчлэн ур хийцийн хувьд дахин давтагдашгүй үзмэрүүдээр сан хөмрөгөө баяжууллаа.

Эрдэнэсийн санд хадгалагдаж буй Богд хаан болоод Дондогдулам хатны эдэлж, хэрэглэж байсан түүхийн хосгүй үнэт эд зүйлс болон бусад үзмэрт анх удаа олон улсын стандартын дагуу үнэлгээ хийлгэсний үр дүнд Эрдэнэсийн сангийн үнэлгээ нэг их наяд төгрөг хүрч, сан хөмрөгийг хадгалан хамгаалж, хойч үедээ өвлүүлэн үлдээх зорилт баталгаажив. Эрдэнэсийн сан нь Архангай аймгийн Өндөр–Улаан сумын нутгаас олдсон Монгол Улсын хосгүй үнэт зүйлд бүртгэгдсэн Хүннүгийн үеийн 78 ширхэг эд зүйл,

**МОНГОЛ УЛСЫН
ЭРДЭНЭСИЙН
САНГИЙН ЭД ЗҮЙЛСТ
АНХ УДАА ОЛОН
УЛСЫН СТАНДАРТЫН
ДАГУУ ҮНЭЛГЭЭ
ХИЙЛГЭЖ, САН
ХӨМРӨГӨӨ ТҮҮХИЙН
ХОСГҮЙ ҮНЭТ
ОЛДВОРУУДААР
БАЯЖУУЛЛАА.**

**ГАДААД ВАЛЮТЫН
УЛСЫН НӨӨЦ СҮҮЛИЙН 6
ЖИЛИЙН ХАМГИЙН ӨНДӨР
ТҮВШИНД ХҮРЭВ.**

Гадаад валютын улсын нөөц 2018 оны 12-р сарын байдлаар 3.5 тэрбум ам.долларт хүрсэн нь сүүлийн 6 жилийн хамгийн өндөр үзүүлэлтэд хүрэв. Гадаад валютын улсын нөөцийг нэмэгдүүлэх гол эх үүсвэр нь Монголбанкны худалдан авсан алтны хэмжээ нэмэгдсэн явдал байв. Уул уурхайн томоохон төслүүдийн хөрөнгө оруулалт хэвийн үргэлжилсэн, экспортын гол түүхий эдийн үнэ, эрэлт тогтвортой байсан, ОУВС-ийн “Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр” амжилттай хэрэгжиж байгаа, банк, санхүүгийн байгууллагууд олон улсын санхүүгийн зах зээлээс хөнгөлөлттэй эх үүсвэр татсан зэрэг нь гадаад валютын улсын нөөцийг нэмэгдүүлэхэд гол түлхэц боллоо.



Олон улсын төв банкны жишигт хүрэх, дэлхий нийтээр хэрэгжүүлж буй бодлогын шинэ сорилт, түүнийг судлах, төлбөрийн системийн шинэ техник технологийг нэвтрүүлэхэд анхаарч гадаад хамтын ажиллагааныхаа цар хүрээг тэлж, үр өгөөжийг нь нэмэгдүүлэх шинэ алхам хийв. Энэ хүрээнд ОХУ, БНХАУ, Испани, Ирланд, Тайланд, Казакстаны Төв банктai олон талын хамтын ажиллагааг өргөжүүлэн, Олон улсын төлбөр тооцооны банкинд гишүүнээр элсэх нөхцөлийг бүрдүүлэв. Мөн БНСУ-ын Төв банктai хамтран хэрэгжүүлж буй “Мэдлэг” түншлэлийн хөтөлбөрийн хүрээнд “Санхүүгийн тогтвортой байдал, Макро зохистой бодлого ба институци” сэдэвт судалгааг амжилттай хийж гүйцэтгэв.

**ГАДААД ХАРИЛЦАА,
ОЛОН УЛСЫН ХАМТЫН
АЖИЛЛАГААГАА
ӨРГӨЖҮҮЛЭХ
БОДЛОГЫН ТОМООХОН
АЛХМУУДЫГ ХИЙЛЭЭ.**

**БАНК, САНХҮҮГИЙН
САЛБАРЫН
ТОГТВОРТОЙ БАЙДЛЫГ
ХАНГАХ БОДЛОГЫН
ХЭРЭГЖИЛТИЙН
НЭГДСЭН УЯЛДААГ
ХАНГАЖ, ТУЛГАМДСАН
АСУУДЛУУДАА ХАМТРАН
ХЭЛЭЛЦЭХ БАНК
САНХҮҮГИЙН САЛБАРЫН
АЖИЛТНЫ БҮСИЙН
ЗӨВЛӨГӨӨНИЙГ ЗОХИОН
БАЙГУУЛЛАА. БҮСИЙН
ЗӨВЛӨГӨӨНӨӨС ИРГЭДИЙН
САНАЛ ХҮСЭЛТЭД
ТУЛГУУРЛАН САНХҮҮГИЙН
БҮТЭЭГДЭХҮҮН,
ҮЙЛЧИЛГЭЭГ ТЭГШ
ХҮРТЭЭХ БОЛОМЖИЙГ
НЭМЭГДҮҮЛЭХ
ШИЙДВЭРИЙГ ГАРГАВ.**

Банк санхүүгийн салбарын бүсийн Ажилтны зөвлөгөөнийг 2017 онд санаачлан зохион байгуулж, орон нутаг дахь Монголбанкны салбар, хэлтсийн удирдлага, мэргэжилтнүүдийн дотоод үйл ажиллагааны чиг үүргийн хүрээнд хэлэлцүүлэг уулзалт, сургалт зохион байгуулж байв. Харин 2018 оноос хамрах хүрээг нь өргөжүүлж, орон нутгийн засаг захиргаа, арилжааны банкны удирдлагууд болон олон улсын банк, санхүүгийн байгууллагуудын төлөөлөгчдийг оролцуулсан уулзалт хэлэлцүүлгийг Хэнтий, Хөвсгөл, Говь-Алтай аймагт хийлээ. Энэ удаа мөнгөний бодлогын шийдвэрийн хэрэгжилт, банкны салбарын хууль, эрх зүйн шинэчлэлийн хөтөлбөрийг хэрэгжүүлж буй үйл ажиллагааны талаар мэдээлэл танилцуулга хийж, “Банкны эрх зүйн шинэчлэл, хяналт шалгалтын чиг хандлага, цаашдын хамтын ажиллагаа” сэдвээр хэлэлцүүлэг хийсэн юм. Энэ үеэр Зээлийн мэдээллийн сантай холбоотой хүсэлтүүдийг нягтлан шалгаж, зарим мэдээллийг хэвийн ангилалд шилжүүлэх 2 удаагийн шийдвэрийг гаргаснаар тавигдсан нөхцөлүүдийг хангасан нийт 55255 иргэний мэдээлэл Зээлийн мэдээллийн сангийн хэвийн ангилалд шилжлээ.





Макро зохистой бодлого

Санхүүгийн тогтвортой байдлыг хангах

Санхүүгийн системийн дархлааг бэхжүүлэх

Системийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх

Макро зохистой бодлогын зорилго нь:

Системийн эрсдэл хуримтлагдахаас сэргийлж, санхүүгийн тогтвортой байдлыг хангах.

Нийгмийн сайн сайхан байдлыг хамгийн өндөрт байлгахад чиглэж дараах зорилтуудыг хангана.

Зээлийн хэт өсөлт үүсэх, хөрөнгийн үнэ хөөсрөхөөс урьдчилан сэргийлэх.

Хөрвөх чадварын эрсдэлийг удирдах, хязгаарлах.

Төвлөрлийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх.

Системийн хэмжээнд эрсдэл хуримтлуулдаг механизмуудыг хязгаарлах.

Санхүүгийн дэд бүтцийн уян хатан байдлыг бэхжүүлэх.

Мөнгөний бодлого



30

150%

Үнийн тогтвортой байдал

Мөнгөний бодлогын хорооны шийдвэрээр, 2019.01.01-ний өдөр хэрэгжих "Макро зохистой бодлогын" зохицуулалтууд:

- Хэрэглээний зээлийн өр орлогын харьцааны дээд хязгаарыг **70 хувиар** тогтоон мөрдүүлэх - Ингэснээр иргэдийг **өрийн дарамтад** орохоос сэргийлж, санхүүгийн салбарт эрсдэл хуримтлагдахаас сэргийлэх;
- Ипотекийн бус иргэдийн хэрэглээний зээлийн хугацааг **30 сараас** хэтрүүлэхгүй байх - Улмаар санхүүгийн тогтвортой байдалд сөргөөр нөлөөлж болзошгүй **эрсдэл хуримтлагдахаас** сэргийлэх;
- ААН-д олгосон ханшийн эрсдэлтэй валютын зээлийн эрсдэлийн жинг **150 хувь** болгон нэмэгдүүлэх - Энэ нь ханшийн эрсдэлээс сэргийлж, банкуудын валютаар биш **төгрөгөөр зээл олголтыг** дэмжинэ.

Макро зохистой бодлого

Санхүүгийн тогтвортой байдал



САНХҮҮГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ТОГТВОРТОЙ БАЙДАЛ 2018 ОНД

“Блүүмбэрг ТВ Монголиа” 12 дугаар сарын 18-ны өдөр “Finance Forum-2018” арга хэмжээг хоёр дахь удаагаа зохион байгууллаа. Хэлэлцүүлэгт Монголбанк, Сангийн яам, банк болон банк бус санхүүгийн байгууллагуудын төлөөлөл оролцож, 2018 оны туршид эдийн засаг, санхүүгийн зах зээлд өрнөсөн үйл явц, 2019 онд анхаарах асуудлуудын талаар өөр өөрсдийн байр сууриа илэрхийлэв.



САНГИЙН ДЭД САЙД **Х.БУЛГАНТУЯА**

Төсвийн хөрөнгө оруулалтыг 4 жилийн Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт ерөнхийдөө тусгасан. Ингэхдээ нийгэм, эдийн засгийн гол тулгамдаад байгаа асуудлууд руу чиглүүлж байна. УИХ болон нийгмээс тавьж байгаа гол асуулт нь эдийн засгийн өсөлтийг дэмжих төсөл хөтөлбөрүүдэд хөрөнгө оруулалт хангалттай биш байна гэж ярьж байна. 2019 оны хувьд сургууль, цэцэрлэг, эрүүл мэндийн салбарт илүү их хөрөнгө оруулалт хийхээр тусгасан. Нийтдээ 100 гаруй сургууль, мөн тооны цэцэрлэг барихаар төсөвлөсөн. Монголын эдийн засгийн хувьд бүтцийн реформ гэдэг зүйл эдийн засгийн өсөлтөөс илүү чухал. Учир нь энэ цаг хугацаанд төсвийн дэмжлэг аваад төлбөрийн тэнцлийг сайжруулсан ч гэсэн, эсвэл Монголбанк своп хэлцэл хийсэн ч урт хугацаанд энэ бодлогын алдаа, дутагдлыг засах дээр төсөв улстөржихгүй байх нь илүү чухал. Энэ оны эхээр Засгийн газар Монгол Улсад анх удаагаа 5 жилийн хугацаатай “Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр” гэдгийг баталсан. Өнөөгийн нөхцөлд төсөв батлуулах үеэр маш олон жижиг хэмжээний хөрөнгө оруулалтын төслүүд батлагддаг. Угтаа бол эдийн засгийн, хөгжлийн том хөтөлбөрүүдийг дагаж улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрүүд батлагдаад аливаа улс төрийн хүчнээс үл хамаарч хэрэгжээд, санхүүжигдээд явах нь зүйтэй. Мөн урт хугацаанд аль салбар руу чиглэх нь үр өгөөжтэй вэ гэх зэрэг тооцооллуудыг тусгах нь зөв юм.



МОНГОЛБАНКНЫ ТЭРГҮҮН ДЭД
ЕРӨНХИЙЛӨГЧ **О.ЭРДЭМБИЛЭГ**

Мөнгөний бодлогын орон зайны хувьд Төв банкны үнэт цаас 4.5 их наяд төгрөг байна. Абсолют дүн, тоог харвал өндөр мэт боловч яг харьцуулбал 2010 онд Төв банкны болон Засгийн газрын нийт үнэт цаасны банкуудын активт эзлэх хувь 18 хувь байсан. Харин 2018 оны 11 дүгээр сарын тоог харвал Төв банкны үнэт цаас, засгийн газрын үнэт цаасны нийт системийн активт эзлэх хэмжээ 20 хувьд хүрээд байна. Тэгэхээр энэ тоо өндөр харагдаж байгаа нь банкны систем 5 дахин өссөнтэй холбоотой. Хоёрдугаарт, орон зайны хувьд Монголбанк баланс ярих ёстой. Төв банк ашиг эсвэл алдагдалтай байх чухал нь биш. Хамгийн гол нь мөнгөний бодлогын орон зай гэдэг өнцгөөс яриад байгаа юм. Төв банкны хуримтлагдсан алдагдал 3 их наяд төгрөг болж буурсан. Өрийн тогтвортой байдлыг хангахтай холбоотойгоор төсөв дээр 2020, 2021 онд хязгаарлалт бий болсноор эдийн засгийн идэвхжлийг хангах орон зай хумигдах төлөвтэй байна. Энэ тохиолдолд Монголбанк түүнийг нөхөх мөнгөний бодлогын орон зайг одооноос бий болгох хэрэгтэй. Өөр нэг орон зай нь валютын нөөцийг нэмэгдүүлэх асуудал юм. Гэхдээ нөөцийг нэмэгдүүлнэ гэхээр Монголд орж ирж байгаа доллар болгоныг Төв банк авна гэсэн үг биш. Интервенц гэдэг бол хоёр чиглэлтэй. Зарим үед зарна, зарим үед валют худалдаж авна. Тиймээс ч цэвэр интервенц гэж ярьж байх нь зөв. Мэдээллийн хувьд Төв банк бусад зах зээлд оролцогч талуудаас илүү мэдээлэлтэй байдаг учраас ашиг хонжоо хайсан, спекуляци хийсэн хүмүүсийг дандаа алдагдалд оруулах шийдвэрүүдийг гаргаж ирсэн.



АЗИЙН ХӨГЖЛИЙН БАНКНЫ ЭДИЙН ЗАСАГЧ **Л.АМАР**

Валютын сангийн хөтөлбөрийн хүрээнд Азийн Хөгжлийн Банкнаас сүүлийн 2 жилийн хугацаанд ойролцоогоор 500 сая ам.долларын санхүүжилт олгоод байна. Үүнээс 300 орчим сая ам.доллар нь төсвийн дэмжлэг болсон. Ирэх жилүүдэд төсвийн дэмжлэгийг үргэлжлүүлнэ. Жишээлбэл, ирэх жилд 100-150 сая ам.долларын төсвийн дэмжлэг үзүүлэхээр байна. Мөн 200 орчим сая ам.долларын төсөл шинээр батлуулахаар ажиллаж байна. Бүтцийн талаар ярихад богино хугацаанд харахаас илүү урт хугацааны бодлого явуулах нь зохистой. 2020 оны эхээр Валютын Сангийн хөтөлбөр дуусна, мөн 2021 оноос эхлэн томоохон хэмжээний зээлийн төлбөр яригдаж эхэлнэ. Түүнчлэн Монголбанк БНХАУ-ын Төв банктай хийсэн валютын своп хэлцлийн сунгалтын асуудал ч дахин яригдана. Тэгэхээр 2021 он гэхэд Монгол Улс эргээд 2016 оных шиг хүнд нөхцөл байдалд орохгүй байх нь чухал. Үүний тулд 2019 оны төсөв болон мөнгөний бодлого чухал үүрэгтэй. Одоогоор Төсвийн Тогтвортой Байдлын тухай хуулийг бүрэн хэрэгжүүлж чадаагүй байна. Уг хууль 2011 онд батлагдсанаас хойш 12 удаа өөрчлөлт оруулсан бөгөөд дараагаар нь Засгийн газрын Тусгай сангийн талаарх хуулийг өөрчлөөд Төсвийн тогтвортой байдлын сангаас хөрөнгө авч ашиглах болсон. Тэгэхээр, нөөцөө бүрдүүлж чадахгүй бол сөрөг шокноос эдийн засгаа хамгаалах орон зай дутагдах болно. 2019 оны хувьд нэгдүгээрт өр төлбөрөө бууруулах, хоёрдугаарт нөөцөө нэмэгдүүлэх тал дээр анхаарах хэрэгтэй.



МӨНГӨНИЙ БОДЛОГЫН ХОРООНЫ ГИШҮҮН, ЭДИЙН ЗАСАГЧ **Ч.ХАШЧУЛУУН**

2018 оны хувьд миний бодлоор мөнгө, төсөв, санхүүгийн бодлогын хувьд тун сайн, амжилттай жил боллоо гэж харж байна. Сангийн яам Засгийн газар, эсвэл Монголбанкнаас ч тэр 2018 оныг ийм сайн жил болно гэж төсөөлөөгүй байсан. Эргээд үр дүнгүүдийг харахад ер нь их оновчтой бодлого хэрэгжүүлжээ. Мэдээж энд гадаад зах зээлийн нөлөө байсан. Гэхдээ гадаад зах зээл сэргэсэн энэ боломжийг эергээр ашиглаж чадсан. Оны эцэст инфляци, ханш өссөн нь эдийн засгийн өсөлтөөс үүдэлтэй. Оны сүүлээр манай эдийн засаг эрчимжиж, өсөлт нь төсөөлж байснаас өндөр байсны үр дүн болов уу. Монголбанкнаас ч холбогдох арга хэмжээг цаг тухайд нь авсан. Одоогийн байдлаар ханш тогтворжсон байна. Инфляцийн хувьд тун цөөхөн барааны үнийн өсөлттэй холбоотойгоор бий болсон, их өвөрмөц өсөлттэй байна. Цөөхөн барааны дотор мах байгаа. Энэ нь их сонирхолтой. Олон улсын байгууллагууд Монголыг эдийн засгаа төрөлжүүлэхийг зөвлөдөг. Одоо төрөлжилтийн эхлэл болж байна. Манай хөдөө аж ахуйн салбар дэлхийн зах зээл дээр бага багаар гарч эхэлж байна. Иран, БНХАУ-руу мах гаргаж эхэлж байгаа нь эргээд махны үнийг дэлхийн зах зээлээс хамааралтайгаар өсгөх чиглэлд хүргэсэн.



Н.Батсайхан Хяналт шалгалтын газрын захирал

ЭРСДЭЛЭЭС СЭРГИЙЛСЭН БАНКНЫ ХЯНАЛТ ШАЛГАЛТЫГ ДЭЛХИЙ НИЙТЭЭР МӨРДӨЖ БАЙНА

АНЭУ-ын Абу Даби хотноо 11 дүгээр сарын 26-30-нд Банкны Хяналт Шалгалтын Олон Улсын Хурал боллоо.

Олон улсын санхүүгийн зах зээлд тогтворгүй байдал үүссэнээр Их 10-ын Төв банкны тэргүүнүүд банкнийг хянаж, зохицуулах хороог анх 1974 байгуулсан нь хожим Базелийн Хяналт Шалгалтын Хороо болж, Банкны Хяналт Шалгалтын Олон Улсын Хурлыг 1979 оноос эхэлж 2 жил тутамд зохион байгуулдаг болсон уламжлалтай.

Зуу гаруй улсын Төв банкны удирдах түвшний албан тушаалтнууд, хянан шалгагч нар болон олон улсын санхүүгийн байгууллагуудын удирдлагууд оролцож, банкны хяналт шалгалтын үйл ажиллагаанд тулгарч буй асуудлуудыг бодлогын түвшинд хэлэлцэн олон улсын хамтын үйл ажиллагааг идэвхжүүлэхэд санал бодлоо солилцох боломж олгодгоороо энэ хурал чухал ач холбогдолтой юм. Энэ удаагийн хурлаар олон асуудал хэлэлцсэний дотор Базел III стандартын хэрэгжилт илүүтэй анхаарлын төв дэх сэдэв байв.

Банкуудын өөрийн хөрөнгийг тооцох аргачлал болон стандартын хүрэн дэх олон улсын нийцлийг бий болгохын тулд 1988 онд Базел I стандартыг дээрх байгууллагаас гаргаж байв. Энэ баримт бичиг батлагдсанаар банкуудын балансын болон балансын гадуурх бүртгэлд өөрийн хөрөнгө хүрэлцээтэй байгаа эсэхийг тодорхойлох замаар зээлийн эрсдэлийг анхаардаг болсон. Үүнээс хойш Базел II стандартад 2004 оноос шилжиж, өөрийн хөрөнгийн шинэчилсэн тогтолцоог бий болгож, үйл ажиллагааны эрсдэлийг багтаажээ. Харин 2010 оноос Базел III стандартыг хэрэгжүүлэх болсон нь улс орныг дамнасан санхүүгийн хямралаас үүдэлтэй банкны салбарт шинэ стандартуудыг тодорхойлох шаардлага тулсантай холбоотой юм.

БАЗЕЛ III СТАНДАРТ ЮУНД ЗОРЬСОН БОЛОХЫГ ТӨВ БАНКУУД ХЭЛЭЛЦЭВ

2008 онд болсон дэлхийн санхүүгийн хямралаас хойш

арван жил өнгөрчээ. Түүнээс хойш Базелийн хяналт шалгалтын хороо нь санхүүгийн хямралаас сургамж авч олон улсын хэмжээний томоохон банкуудын санхүүгийн чадавхийг сайжруулах зорилгоор хяналт шалгалтын стандартуудыг шинэчилж ирсэн нь Базел III стандартыг хэрэгжүүлэх болсон юм. Энэ нь 2008 онд мөрдөж байсан стандартаас маш олон зүйлээр ялгаатай. Тухайлбал, өөрийн хөрөнгийн зохистой харьцааг нэмэгдүүлж, түүний чанарт илүү өндөр шаардлагыг тавьдаг болсон, төлбөр түргэн гүйцэтгэх чадварын шинэ стандартыг нэвтрүүлсэн, өөрийн хөрөнгийн хүрэлцээг тухайн банкны эрсдэлийн түвшинд нийцүүлэн тооцдог болсон, мөн системийн эрсдэлийг бууруулах макро зохистой харьцааг нэвтрүүлсэн. Санхүүгийн хямралын дараах шинэчлэл нь ерөнхийдөө 2017 оны 12 дугаар сард дууссан байдаг.

Базелийн хороо нь 2017 оны 3 дугаар сард Базел III стандарт, зохицуулагч байгууллагаас тавьж буй шаардлагад орсон өөрчлөлтүүд нь макро эдийн засаг, банкны үйл ажиллагаанд ямар нөлөө үзүүлсэн талаарх үнэлгээг хийхээр тохиролцсон. Энэ үнэлгээ нь хяналт шалгалтын шинэ стандарт анхны зорилгодоо хүрсэн эсэх, хүсээгүй буюу урьдчилж тооцоогүй үр дагавар гарч ирсэн эсэхийг дүгнэхэд чиглэгдсэн юм. Базелийн хяналт шалгалтын хороо нь үнэлгээний ажлын төлөвлөгөөг боловсруулж, ажлын хэсгүүд ажлаа нэгэнт эхэлжээ. Тус үнэлгээний ажил нь Базел III стандартыг хэрэгжүүлэх явцад хийгдэх ч хэдэн жилээр ч үргэлжлэхээр байна.

Базелийн Хороо нь өөрийн хөрөнгийн шаардлагад орсон өөрчлөлт нь олон улсын томоохон банкуудын өөрийн хөрөнгө, тэр дундаа, нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгөд ямар нөлөө үзүүлснийг судлахад тус банкуудын нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө 2015 онтой харьцуулахад 1.7 хувиар нэмэгдсэн байна. Үүнээс үзэхэд Хяналт Шалгалтын Хороо нь ерөнхийдөө анх тавьсан зорилгодоо хүрсэн гэж дүгнэсэн ч цаашид энэ судалгааг үргэлжлүүлэн хийнэ гэдгээ хурлын үеэр мэдэгдсэн юм.

Базел III стандартаар хоёр төрлийн төлбөр түргэн гүйцэтгэх чадварын шаардлага хэрэгжиж эхэлсэн. Нэгт, богино хугацааны буюу 30 хоногийн төлбөр түргэн гүйцэтгэх чадвар, хоёрт, харьцангуй урт хугацааны төлбөр түргэн гүйцэтгэх чадвар. Эхний

тохиолдолд банк өндөр хөрвөх чадвартай хөрөнгийг шаардлагатай түвшинд төвлөрүүлэх ёстой бол сүүлийн тохиолдолд урт хугацаанд тогтвортой эх үүсвэрийг татан төвлөрүүлэх нь чухал. Базелийн Хороо нь төлбөр түргэн гүйцэтгэх чадвартай холбоотой шаардлагууд банкны үйл ажиллагаанд хэрхэн нөлөөлж байгааг, тус шаардлага нь анхны зорилго, зорилтод хүрсэн эсэхийг үнэлэх ажлыг эхлүүлж байгаа. Мөн Хяналт Шалгалтын Хороо нь банкны хяналт шалгалтын шинэ стандарт, тэр дундаа, өөрийн хөрөнгө, төлбөр түргэн гүйцэтгэх чадварын шаардлагууд макро эдийн засагт ямар нөлөө үзүүлснийг судалсан байна. Тухайлбал, Базел III стандарт нь илүү хүчирхэг, тогтвортой санхүүгийн салбарын суурь болж банкны системийн хямралаас урьдчилан сэргийлэх давуу талыг бий болгосон бол зээлийн хүүгийн түвшин нэмэгдсэн нь сул талтай гэж дүгнэсэн байна.

Сүүлийн жилүүдэд банкууд өөрийн хөрөнгийн чанарыг сайжруулах, төлбөр түргэн гүйцэтгэх чадварын нэмэлт шаардлагыг хангах тал дээр багагүй ахиц гаргасан гэж дүгнэжээ. Тухайлбал, 2011 оноос хойш олон улсын томоохон банкуудын нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгийн хэмжээ (СЕТ1%) 84% буюу 1.7 их наяд еврогоор өссөн байна. Банкуудын хөшүүргийн харьцаа 2015 он хүртэл тогтмол өсөж, 2015 оноос хойш тогтвортой байгаа хэдий ч санхүүгийн хямралын дараа мэдэгдэхүйц хэмжээгээр буурсан байна. Мөн богино хугацааны төлбөрийн чадварын хувьд гэвэл

2012 оноос хурдан хугацаанд хөрвөх чадвартай хөрөнгийн хэмжээ 4 их наяд еврогоор нэмэгдсэн эерэг үзүүлэлтүүд ажиглагдаж байна.

МАНАЙ УЛСАД ХЭРЭГЖИЖ БҮЙ БАЙДАЛ

Банкуудын “эрүүл мэнд”-ийг зөв оношилж, цаашид авах арга хэмжээгээ тодорхойлохын тулд ОУВС-ийн хөтөлбөрийн хүрээнд Монголбанк олон улсын стандартад нийцсэн аргачлалаар банкуудын активын чанар, эрсдэлийн удирдлагын тогтолцоог үнэллээ. Азид анх удаа манай улс олон улсын стандартаар активын чанарын үнэлгээг хийлгэсэн нь энэ юм. Тус үнэлгээгээр уул уурхайн лицензийн үнэлгээний аргачлалыг тодорхойлсон нь бусад улс орнуудад хийгддэг активын чанарын үнэлгээнээс онцгой ач холбогдолтой болсон юм.

Активын чанарын үр дүнд банкууд өөрийн хөрөнгөө шаардлагатай түвшинд нэмэгдүүлэхээр болж, он гарсаар банкны системийн хэмжээнд хувь нийлүүлсэн хөрөнгө 140 тэрбум гаруй төгрөгөөр нэмэгдсэн юм. Мөн одоогийн байдлаар банкуудаас өөрийн хөрөнгөө нэмэгдүүлэх хүсэлтүүд ирж Монголбанк зөвшөөрөл олгох эсэхийг судалж байна. Активын чанарын үнэлгээний үр дүнд санхүүгийн зуучлагчийн гол үүргийг гүйцэтгэдэг банкуудын эрсдэл даах чадвар сайжирсан тул эдийн засгийн өсөлтийг дэмжих нөхцөл бий болсон. Монголбанк банкуудын активын чанарын үнэлгээг олон улсын туршлагатай зөвлөхөөр хараат бус байдлаар

амжилттай гүйцэтгэсэн тул Азийн бусад орнууд активын чанарын үнэлгээг хийлгэх эрмэлзэлтэй байна.

“Их 20” улсын удирдагчид Базел III стандартыг олон улсын санхүүгийн системд нэгэн зэрэг, бүхэлд нь, тогтоосон хугацаанд нэвтрүүлэхийг тогтмол уриалж ажиллаж байгаа хэдий ч тус стандартыг нэвтрүүлэхтэй холбогдуулан хийх ажил маш их байна. Санхүүгийн хямралын дараах шинэчлэл буюу Базел III стандарт нь 2022 он гэхэд бүхэлдээ хэрэгжиж дуусан үр дүнгээ өгнө. Базел III стандартыг шат дараатай хэрэгжүүлж эхлэх явцад зарим стандартууд эхлэх хугацаанаасаа хоцорч эхэлсэн. Тухайлбал, гишүүн орнууд дотооддоо харилцагчийн зээлийн эрсдэлийг тодорхойлох стандартчилсан аргачлалыг нэвтрүүлэх, төлбөр тооцооны төвлөрсөн клирингийн төвийн зээлийн эрсдэлийг тодорхойлох аргачлалыг нэвтрүүлэх гэх зэрэг хүндрэл тулгарсан тул зарим стандарт хоцорч хэрэгжиж эхэлсэн юм. Базелийн Хяналт Шалгалтын Хороо нь Базел III стандартыг гишүүн орнууд шат дараатай хэрэгжүүлэх үйл ажиллаганд хяналт тавих зорилгоор 2012 онд RCAP үнэлгээний хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр болов. Энэ хөтөлбөрийн гол зорилго нь гишүүн орнууд Базел III стандартыг тогтсон хугацаанд зохистой байдлаар хэрэгжүүлж эхэлсэн эсэхэд үнэлгээ хийх юм. Тус хөтөлбөр нь үнэлгээний үр дүнг Хяналт Шалгалтын Хорооны цахим хуудсанд албан ёсоор нийтэлдэг. Эрсдэлд суурилсан өөрийн хөрөнгийн хүрэлцээг тооцох стандартыг нэвтрүүлэх явцад

1200 гаруй “зөрчил, гажуудлыг” илрүүлсэн байна. Базелийн хорооны гишүүн орнуудын гуравны хоёр нь тус стандартыг бүрэн, эсвэл бүхэлд нь нэвтрүүлсэн дүгнэлт гарч байжээ. Улс орнуудын хяналт шалгалтын эрх зүйн орчин хоорондоо ижил биш, мөн өөрийн соёл, заншил, бизнесийн хэв маягтай байдаг учир бүгд ижил дүрэм, журам мөрдөх боломжгүй. Харин үүний оронд өөрийн хууль, журамд өөрчлөлт оруулан олон улсын стандартыг мөрдөх нь чухал, өөрөөр хэлбэл үр дүн нь чухал юм.

Базелийн Хяналт Шалгалтын Хороо олон улсын санхүүгийн хямралын дараа шат дараатай шинэчлэлийг хийж үр дүнд хүрсэн ч хяналт шалгалтын стандартууд хэмжээний хувьд улам их, хэрэгжүүлэхэд төвөгтэй болсон. Тиймээс улс орнуудын зохицуулагч байгуулагуудад тус стандартуудыг дотоодын хууль, дүрэм, журамд тусгахад хүндрэл үүсэж болзошгүй. Иймд пропорциональ зарчим буюу банкуудын банкны системд эзлэх хэмжээнээс нь хамаарч хяналт шалгалтын стратегийг тодорхойлох асуудал нэн чухал асуудал болж байна. Өөрөөр хэлбэл, тухайн банкны эрсдэлийн түвшнээс хамаарч түүнд тохирсон хяналт шалгалтын дүрмийг тодорхойлно гэсэн үг. Энэ зарчим нь хяналт шалгалтын үр ашигтай байдлыг нэмэгдүүлэх, хяналт шалгалтын үйл ажиллагааг хялбаршуулах, банкуудыг тодорхой шалгуураар ангилах зэрэг давуу далтай. Гэхдээ бас сул тал бий. Банкны системийн нэгдсэн хяналт шалгалтыг илүү ярвигтай болгох, банкууд өөрийн эрсдэлийн

түвшинг зохистой байдлаар бууруулахаас илүүтэй хяналт шалгалтын шаардлагад нийцүүлэн бизнес загвараа тодорхойлох боломжтойгоор ашиглах болсон.

Базел II, III стандартууд олон улсын банкуудад илүү хамааралтай. Иймд тухайн гишүүн орны бүх банкууд энэ стандартыг заавал дагаж мөрдөхийг, мөн гишүүн биш улс орнууд Базелийн стандартыг мөрдөхийг шаарддаггүй. Гэхдээ Базелийн Хороо нь банкны эрсдэлийн түвшин, банкны системд эзлэх хэмжээнээс нь хамааран хяналт шалгалтын стандартыг тогтоох буюу пропорциональ зарчмыг хүлээн зөвшөөрдөг. Базелийн хорооны гишүүн орнуудын 75% нь тус зарчимд үндэслэж хяналт шалгалтын үйл ажиллагааг зохион байгуулдаг байна.

Базел III стандартыг бүрэн хэрэгжүүлэх үйл явц хянан шалгагчийн ур чадвар, хүчин чармайлтаас ихээхэн шалтгаална. Хянан шалгагч шинэ стандарт, дүрмийг маш сайн ойлгож, хяналт шалгалт хийж буй банкныхаа эрсдэлийн түвшинг эдийн засгийн мөчлөгтэй уялдуулан зөв тодорхойлж, хүндрэл үүсэхээс өмнө арга хэмжээ авах сорилттой тулгарч байна. Түүнчлэн шинэ төрлийн эрсдэлийг хянах үүднээс хяналт шалгалтын цар хүрээг илүү өргөн болгох, эрх зүйн орчныг сайжруулах зэрэг асуудал гарч ирсэн. Зохицуулагч байгууллагууд банкуудын бизнесийн шинэ загвар, шинэ технологиос үүсэх эрсдэлийг хянах чадвартай болохын тулд хянан шалгагч нарыг чадавхжуулах,

сургалтын хөтөлбөрийг эргэн харж холбогдох өөрчлөлтүүдийг оруулах шаардлагатай болж байна.

ФИНТЕКИЙН ХӨГЖИЛД БАНКНЫ ХЯНАЛТ ШАЛГАЛТ

Финтек нь өөрөө банкны бизнес загварт ихээхэн нөлөө үзүүлж байна. Шинэ боломжуудыг нээж байгаа хэдий ч шинэ төрлийн эрсдэл үүсгэж байна. Тухайлбал, стратегийн эрсдэл, үйл ажиллагааны эрсдэл, мэдээллийн аюулгүй байдлын эрсдэл, комплаенсийн эрсдэлүүд нэмэгдэнэ. Банкууд харилцагчдад шинэ бүтээгдэхүүн нэвтрүүлэх үүднээс хамгийн дэвшилтэт технологи, тэр дундаа, хиймэл оюун ухаан, үүлэн тооцооллын технологи, блокчейн ашиглаж байна. Иймд эдгээр технологиос үүдэх шинэ эрсдэлүүдийг тооцоолох нь чухал юм. Үүний тулд тухайн банк нь шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээ нэвтрүүлснээр үүсэх эрсдэлийг тооцоолж байгаа эсэхэд, түүнийг бууруулах арга хэмжээ авах чадвар байгаа эсэх, мөн зохистой засаглалд нь хяналт тавьж ажиллах нь чухал байна. Мөн банкны IT хяналт шалгалтыг сайжруулснаар шинэ төрлийн эрсдэлийг хянах боломжтой. Сүүлийн үед банкууд дэвшилтэт технологи ашиглан санхүүгийн үйлчилгээ үзүүлэхдээ аутсорсинг буюу гуравдагч этгээдийн үйлчилгээг ашигладаг болсон. Хэдий банкны үйлчилгээнд гуравдагч этгээдийг ашиглаж болох хэдий ч бүх эрсдэл нь банкинд үлдэж байгаа гэдгийг анхаарах нь зүйтэй. Мөн харилцагч санхүүгийн үйлчилгээг авахдаа заавал биечлэн ирэх шаардлагагүй болж байгаа

энэ цагт мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх эрсдэлийг зөв зохистой байдлаар удирдаж хуульд нийцтэй байдлыг хадгалах зайлшгүй шаардлагатай. Финтек нь банкны бизнес загварыг бүхэлд нь өөрчилж болзошгүй тул үүнтэй зэрэгцүүлэн хяналт шалгалтын арга барил өөрчлөгдөх ёстой гэдэгт төв банкууд нэгдмэл байр суурьтай байна.

“Их 20”-ын 2017 оны уулзалтаар Сангийн сайд, Төв банкны удирдагчид цахим гэмт хэрэг нь үндэсний болон олон улсын санхүүгийн системийн тогтвортой байдалд заналхийлж байгааг онцлон тэмдэглэсэн байдаг. Иймд улс орнууд идэвх чармайлт гарган цахим аюулгүй байдлыг сайжруулах арга хэмжээг нэн даруй хэрэгжүүлэх ёстой. Цахим гэмт хэрэг нь 2014 онд 445 их наяд ам.долларын хохирол учруулсан бол хамгийн сүүлийн мэдээгээр 2017 онд 600 их наяд ам.долларын хохирол учруулсан байна. Энэ нь хар тамхины худалдаа, авлигын хохирлын дараа орох үзүүлэлт юм. 2017 оны судалгаагаар нэг санхүүгийн байгууллага гэхэд л жилдээ 85 удаа цахим халдлагад өртдөг бөгөөд түүний гурван тохиолдлын нэг нь амжилттай болдог байна. Улс орнууд цахим аюулгүй байдал, хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах хуулиудыг баталж эхэлжээ. Мөн харилцагч өөрийн нууц үгийг зөв зохистой байдлаар ашиглах нь хамгийн үр дүнтэй аргуудын нэг байсаар байна. Өөрөөр хэлбэл, бид харилцагчийн санхүүгийн боловсролыг дээшлүүлэх хэрэгтэй.

Санхүүгийн байгууллагууд олон улс, бусад салбарт үйлдэгдэж байгаа цахим халдлагуудыг байнга судалж, түүнээс урьдчилан сэргийлж, байнгын бэлэн байдалтай байх нь чухал аж.

Мөн Базелийн Хяналт Шалгалтын Хороо нь олон улсын цахим аюулгүй байдлын хамтын ажиллагаанд дэмжлэг үзүүлэх зорилгоор энэ оны эхээр үйл ажиллагааны тогтвортой байдлыг хангах зорилгоор ORG (Operational Resilience Working Group)-ийн ажлын хэсгийг байгуулжээ. Тус ажлын хэсэг нь хамгийн түрүүнд цахим аюулгүй байдлын туршлагаудыг судалж, банкны үйл ажиллагааны аюулгүй байдлын бодлого, сул талыг нь үнэлэх зорилготой ажиллаж байна. Манай улсын хувьд Монголбанкны бүтцэд шинээр байгуулагдсан Банкны Хяналт Шалгалтын Хороо нь холбогдох байгууллагуудтай хамтран цахим аюулгүй байдлыг сайжруулах зааварчилгаа, удирдамжийг гаргаж байсан. Банкууд мэдээллийн аюулгүй байдлыг хангах үүднээс зохистой засаглалыг сайжруулах, цахим эрсдэлийг үнэлэх, түүнийг удирдах ажлыг зохион байгуулах, мэдээллийн нууцлалыг сайжруулах, эрсдэлийг удирдах зорилгоор тогтмол сургалт зохион байгуулж, харилцагчийн мэдлэгийг дээшлүүлэх, цахим халдлагад өртөхөд авах арга хэмжээг тодорхой болгох, холбогдох байгууллагуудтай мэдээлэл, туршлага солилцох зэрэг арга хэмжээг авах нь зүйтэй аж.



5000 ТӨГРӨГИЙН ДЭВСГЭРТИЙН ХАМГААЛАЛТЫН ТАНИХ ТЭМДГҮҮД

ТӨВГӨР ХЭВЛЭЛТ

• Монголбанк таван мянган төгрөг гэсэн уйгаржин монгол бичиг.

• 5000 гэсэн араб тоо

• МОНГОЛ УЛС гэсэн эвхмэл монгол бичиг

• 5000 гэсэн уйгаржин тоо

MONGOLBANK гэсэн микро бичилтүүд

Дэвсгэртийн хоёр талд байрлах Чингис хааны гэрэг дэх дугуй дүрсүүд зөрүүгүй давхцана.



Соёмбо нь 3D эффекттэй, дээш, доош, налуу хөдөлгөхөд өнгө нь солонгорч хөдөлж харагдах СПАРК элемент



УСАН ХЭЭ

Гэрлийн эсрэг тодорч харагдах Чингис хааны хөрөг, $\frac{1}{10}$ гэсэн дүрс



Хуруунд тэмтрэгдэх морьтон баатрын дүрс



2 мм-ийн өргөнтэй тасалдаж харагдах металл туузыг гэрлийн эсрэг барьж харахад MONGOLBANK гэсэн бичиг харагдана.



Дэвсгэртийн суурь өнгөний хээ нь хувилахаас хамгаалсан хийцтэй.

ХЭТ ЯГААН ТУЯАНД ГЭРЭЛТЭЖ ХАРАГДАХ ХАМГААЛАЛТЫН ЭЛЕМЕНТ

Монгол Улс гэсэн эвхмэл монгол бичиг

Чингис хааны хөрөг, 5000 гэсэн уйгаржин монгол бичиг

Шар, ногоон, цэнхэр өнгийн хялгасан утас



Улаан өнгийн серийн дугаар

AQ0006994

Морьтон баатрын дүрс



Тасалдаж харагдах металл тууз

1994 оны 5000 төгрөгийн дэвсгэртийн онцлог:
- Нүүрэн талд байрлах Соёмбо нь энгийн хэвлэлтээр хэвлэгдсэн.
- Чингис хааны хөрөг бүхий усан хээтэй боловч $\frac{1}{10}$ гэсэн дүрс байхгүй.

2003, 2013 оны 5000 төгрөгийн дэвсгэртийн онцлог:
- Нүүрэн талд байрлах Соёмбо нь мөнгөлөг металл дардсаар хэвлэгдсэн.

Монголбанк нь 5000 төгрөгийн дэвсгэртэд сүүлийн үеийн шинэ технологиор хийсэн хамгаалалтын элементийг оруулан сайжруулав.

Манай улсад хуурамчаар үйлдэгдэж буй мөнгөн тэмдэгтүүд нь ихэвчлэн хамгийн өндөр дүнтэй 5000, 10000, 20000 төгрөгийн дэвсгэртүүд байдаг тул эдгээр 3 дэвсгэртийн жинхэнэ эсэхийг шууд төвөггүй таних боломжтой, мөн хуурамчаар дуурайлган хийх

боломжгүй шинэ элементтэй болгон сайжруулахад анхаарч байна.

Энэхүү ажлын хүрээнд 5000 төгрөгийн дэвсгэртийн нүүрэн талд байрлах Соёмбод сүүлийн үеийн дэвшилтэт технологиор хийсэн 3-н хэмжээст хөдөлгөөнтэй, дээш, доош, налуу хөдөлгөхөд өнгө нь солонгорч харагдах Спарк бэхэн элемент оруулж өгснөөр иргэд жинхэнэ мөнгөн тэмдэгтийг хуурамчаас ялгаж танихад хялбар

болголоо.

Монголбанкны Ерөнхийлөгчийн тушаалаар хамгаалалтын элементийг нь шинэчилсэн 5000 төгрөгийн дэвсгэртийг 2019 оны 1 дүгээр улиралд бэлэн мөнгөний гүйлгээнд гаргах бэлтгэл ажил хангагдсан бөгөөд одоо гүйлгээнд байгаа 5000 төгрөгийн дэвсгэрт нь хүчин төгөлдөр хэвээр зэрэгцэн хэрэглэгдэнэ.

ЭДИЙН ЗАСАГ ӨСӨЛТТЭЙ БАЙГАА Ч АНХААРАХ АСУУДЛУУД БАЙСААР БАЙНА...

Эдийн засгийн өсөлт 2018 оны эхний 3 улиралд 6.4 хувьтай байна

Эдийн засгийн өсөлт нь ажлын байрыг нэмэгдүүлэх, өрхийн орлогыг өсгөх эерэг үр дагавартай. Монгол Улсын эдийн засгийн өсөлт 2018 оны эхний 3 улирлын байдлаар 6.4 хувьтай байна. Энэхүү өсөлтөд нийлүүлэлт талаас уул уурхай, боловсруулах, үйлчилгээ, эрчим хүчний салбар голлох эерэг нөлөөг үзүүлсэн байна. Харин эрэлт талаас зах зээлд оролцогчдын итгэл сайжирснаар хэрэглээ, хөрөнгө оруулалт нэмэгдсэн нь голчлон нөлөөллөө.

Зураг 1. Эдийн засгийн өсөлт, түүнд оруулж буй хувь салбаруудаа



Эх үүсвэр: YCX


Энэ оны эхнээс дэлхийн зах зээл дээрх цэвэршүүлсэн эс болон чулуун нүүрсний үнэ өндөр өсөлттэй байсан нь манай эдийн засагт таатай үр дүн авчирсан билээ. Гэсэн хэдий ч 2018 оны төгсгөл болон 2019 онд буурах хандлагатай байна. АНУ-Хятад улсын

худалдааны маргаан цаашид үргэлжилбэл Хятадын нийт үйлдвэрлэлд нөлөөлж тус улсын зэсийн баяжмал, нүүрсний импортыг бууруулах магадлалтай. Улмаар түүхий эдийн үнийг бууруулах сөрөг үр дагавар гарч болзошгүй.

Ажилгүйдлийн түвшин буурч байна ...


Хөдөлмөрийн насны хүн ам 2018 оны 3-р улирлын байдлаар өмнөх оны мөн үеэс 1.3%-иар өсч 2,172 мянгад хүрэв. Эдийн засгийн идэвхгүй хүн ам 840 мянга (өсөлт 4.0%), эдийн засгийн идэвхтэй хүн ам 1,331 мянга (өсөлт 1.6%); үүнд ажиллагчид 1,239 мянга (өсөлт 4.0%), ажилгүй иргэд 92 мянга (өсөлт -22.2%) байна.

Зураг 2. Хөдөлмөрийн насны хүн амын өсөлт



Эх үүсвэр: YCX


Зураг 3. Ажилгүйдлийн түвшин



Эх үүсвэр: ҮСХ

Ажилгүйдлийн түвшин¹ өмнөх оны мөн үеэс 2.2 нэгж хувиар буурч 6.9%-д хүрэв. Нийт ажиллагсад 2018 оны 3 дугаар улирлын байдлаар өмнөх оны мөн үеэс 4.0%-иар нэмэгдэж 1,239 мянга болов. Үүнд барилга (16.7%), боловсруулах (12.7%), уул уурхай (11.7%), тээвэр (9.2%), худалдаа (8.7%) зэрэг үйлдвэрлэл нь идэвхжиж байгаа салбарууд эерэгээр нөлөөлсөн байна.

Зураг 4. Ажиллагсдын өсөлт, салбаруудаар



Эх үүсвэр: ҮСХ

Өрхийн орлого болон дундаж цалин өсч байна


Иргэдийн орлогын үндсэн үзүүлэлтүүдийг авч үзвэл улсын дундаж цалин² 2018 оны 3 дугаар улиралд өмнөх оны мөн үеэс 7.9%-иар өсч 1031.8 мянган төгрөгт хүрээд байгаа бол улсын медиан цалин 6.1%-иар нэмэгдэж 732.7 мянган төгрөг боллоо.

¹ Ажилгүй иргэдийн эдийн засгийн идэвхтэй хүн амд эзлэх хувь

² Эх сурвалж: Нийгмийн даатгалын ерөнхий газрын. Нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайлан

Өрхийн дундаж мөнгөн орлого³ өмнөх оны мөн үеэс 14.7%-иар нэмэгдэж 1,168.5 мянган төгрөг; үүнээс цалингийн орлого 12.1%-иар тэлж 559 мянган төгрөгт хүрээд байна.

Зураг 5. Цалингийн өсөлт



Эх үүсвэр: ҮСХ

Зураг 6. Өрхийн орлогын жилийн өсөлт



Эх үүсвэр: ҮСХ

Зураг 7. Өрхийн орлого, зарлагын дүн, мян.төгрөгөөр




Эх үүсвэр: ҮСХ

³ Эх сурвалж: ҮСХ-ны Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгаа

Эдийн засгийн үйл ажиллагааны үндсэн салбаруудын хувьд дундаж цалин 632-2,394 мянган төгрөгийн интервалд байна. Үйлдвэрлэл нь идэвхжиж буй барилга (жилийн өсөлт 15.9%), ХАА (7.4%), худалдаа (7.2%), уул уурхай (6.1%), боловсруулах (5.7%) болон санхүү (9.4%), боловсрол (8.3%), төрийн захиргаа (7.6%), салбаруудад ажиллагчдын дундаж цалин өсөлттэй байна.

Зураг 8. Цалингийн өсөлт, эдийн засгийн салбарын ангиллаар




Эх үүсвэр: YCX

Өрхийн орлого өсөхийн хэрээр иргэдийн гадаадад аялах нь ихэсч байна ...


Манай улсаас гадаад руу аялж буй жуулчдын тоо болон аяллын импорт өсч байна. Тухайлбал, 2018 оны эхний 10 сарын байдлаар гадаадад аялагчдын тоо 233,231 байгаа нь өнгөрсөн оны мөн үеэс 10%-иар өссөн бөгөөд 2018 оны эцэст 271,816 хүрэх төсөөлөлтэй байна.

Зураг 9. Гадаадад аялсан жуулчлалын зардал, оны эхний 10 сар



Эх үүсвэр: Монголбанк

Зураг 10. Жуулчдын тоо



Эх үүсвэр: ХХЕГ, Монголбанк

Хэрэглээний бүтээгдэхүүний импорт, үүнээс автомашин, сэлбэг хэрэгслийн импорт нэмэгдсэн байна...

Хэрэглээний бүтээгдэхүүний импортын жилийн өсөлт 2018 оны эхний 10 сарын байдлаар 28% байгаа нь өмнөх оны мөн үеэс 18 нэгж хувиар нэмэгдсэн байна. Автомашин (ялангуяа, ланд болон приус машин), сэлбэг хэрэгслийн импорт өнгөрсөн оны мөн үеэс 48%-иар өсчээ. Энэ нь иргэдийн худалдан авах чадвар нэмэгдэж, импортын хэрэглээ өссөнийг илтгэж байна.

Хүснэгт 3. Импорт, сая ам.доллар

Төрөл	Эхний 10 сар			өөрчлөлт	
	2016	2017	2018	2017/16	2018/17
Хэрэглээний бүтээгдэхүүн	956	1,050	1,340	10%	28%
Түргэн эдэлгээтэй	522	594	705	14%	19%
Удаан эдэлгээтэй	434	456	635	5%	39%
Авто машин	261	277	411	6%	48%
Хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүн	981	1,358	2,015	38%	48%
Аж үйлдвэрлэлийн орц	426	454	608	6%	34%
Нефтийн бүтээгдэхүүн	401	663	906	66%	37%
Бусад	5	6	6	30%	-6%
Нийт дүн	2,768	3,530	4,876	28%	38%

Эх үүсвэр: ГЕГ, Монголбанк

Иргэд болон аж, ахуйн нэгжийн зээлийн өсөлт үргэлжилж байна...

Банк, хадгаламжийн байгууллагуудаас олгосон зээлийн үлдэгдэл 2018 оны 10 дугаар сарын байдлаар өмнөх оны мөн үеэс 22.9 хувиар өсчээ. Үүнээс, иргэдэд олгосон зээлийн үлдэгдэл 28.6 хувиар өсч 8.4 их наяд төгрөгт, хувийн байгууллагынх 17.2 хувиар өсч 7.9 их наяд төгрөгт тус тус хүрчээ. Өөрөөр хэлбэл, эдийн засгийн өсөлт, идэвхжил нэмэгдэхийн хэрээр иргэдийн хэрэглээ, бизнес эрхлэгчдийн хөрөнгө оруулалтын санхүүжилт өмнөх жилүүдээс нэмэгдэж байна.



Эх үүсвэр: Монголбанк

Нийт ипотекийн зээл 94259 зээлдэгчийн 4.36 их наяд төгрөг байна. Хөтөлбөрийн эх үүсвэрээр 69359 зээлдэгчид 3.3 их наяд төгрөгийн зээл олгосон байна. Санхүүжилттэй холбоотойгоор ипотекийн зээлийн жилийн өсөлт 2018 оны 1 дүгээр сараас хойш 3-4 хувьтай байна.




Иргэдэд олгосон зээлийн чанар харьцангуй сайн байна ...

Сүүлийн 2 жил орчмын хугацаанд иргэдийн зээлийн чанар харьцангуй тогтвортой буюу хугацаа хэтэрсэн зээл нийт зээлийн 3.1 хувиас хэтрээгүй бол чанаргүй зээл 3.8 хувиас хэтрээгүй үзүүлэлттэй байна.

2018 оны 10-р сарын эцсийн байдлаар иргэдийн нийт зээлд эзлэх хугацаа хэтэрсэн зээл жилийн өмнөх үеэс 0.5 нэгж хувиар, чанаргүй зээл 0.4 нэгж хувиар тус

тус бага үзүүлэлттэй байна.



Эх үүсвэр: Монголбанк

Иргэдийн зээлийн эргэн төлөлт 2018 онд өмнөх онуудаас өндөр байна ...

Иргэдийн зээлийн эргэн төлөлт өмнөх онуудаас нэмэгдсэн байна. Ялангуяа, 2018 оны 4-р сараас хойш зээлийн эргэн төлөлт өмнөх онуудаас өндөр байна. Тухайлбал, 2018 оны эхний 10 сарын байдлаар иргэдийн зээлийн эргэн төлөлт өмнөх оны мөн үеэс 37 хувиар өсөв.



Эх үүсвэр: Монголбанк

Зээлийн эргэн төлөлт өмнөх онуудаас огцом өсч байгаа нь иргэдийн орлого нэмэгдэхийн зэрэгцээ мөн зээлийн олголт өссөнтэй холбоотой байна. Мөн банкуудын санхүүгийн эх үүсвэр нэмэгдсэн, иргэдэд зээл олгох итгэл сэргэснээр шинээр олгож буй зээлийн дүн өмнөх онуудаас өслөө.

Зураг 14. Иргэдэд шинээр олгосон зээл




Эх үүсвэр: Монголбанк

Зээлийн хүү буурч байна ...

Нийт зээлийн үлдэгдлээрх жигнэсэн дундаж хүү (ЖДХ) оны эхэнтэй харьцуулахад буурч 17.4 хувьд хүрсэн нь өмнөх оны мөн үеэс 0.8 нэгж хувиар буурчээ. Үүнээс иргэдийн төгрөгийн зээлийн үлдэгдлийн ЖДХ 18.6 хувьтай, гадаад валютын зээлийн ЖДХ 12.7 хувьтай байна. Хувийн байгууллагын зээлийн ЖДХ 15.6 хувьтай, гадаад валютын зээлийн хүү 10.6 хувьтай байна.

Зураг 15. Зээлийн үлдэгдлийн жигнэсэн дундаж хүү



Эх үүсвэр: Монголбанк

Хадгаламжийн хэмжээ тогтвортой өсч байна...

Нийт хадгаламжийн үлдэгдлийн 88 гаруй хувийг иргэдийн хадгаламж бүрдүүлж байгаа бөгөөд тогтмол өсөлттэй байна. Харин хадгаламжийн хүүний түвшинг харвал төгрөгийн хадгаламжийнх бага зэрэг буурах хандлагатай, валютынх тогтмол түвшинд байна.

Зураг 16. Нийт хадгаламж



Эх үүсвэр: Монголбанк

Экспортын түүхий эдийн барааны үнэ өсөлттэй байна ...

2018 оны эхний 10 сарын байдлаар манай улсын экспортын гол нэрийн бараануудын үнийн түвшин өсөлттэй байна.


Мөн 2018 оны эхний 10 сарын байдлаар уул уурхайн бус экспортын гол түүхийн эд болох түүхий ноолуурын тоо хэмжээ 47%-иар буурсан хэдий ч үнийн дүнгээр 24%-ийн огцом өсөлтийг бий болгосон.

Хүснэгт 4. Түүхий эдийн үнэ, ам.доллар


Экспортын түүхий эдийн хилийн үнэ	2016.10	2017.10	2018.10	Өсөлт 2017/2018
Эсийн баяжмал (1 тонн)	983.9	1,229.9	1,377.1	12.0%
Нүүрс (1 тонн)	40.1	71.5	80.8	13.0%
Нефть (1 тонн)	49.0	50.4	67.2	33.3%
Төмрийн хүдэр (1 тонн)	42.3	44.8	46.5	3.7%
Ноолуур (1000 тонн)	39.9	44.3	67.0	51.3%
Ноос (1000 тонн)	1.3	1.6	2.1	25.8%

Эх үүсвэр: ГЕГ, Монголбанк

Зураг 17. Ноолуурын экспортын дүн



Эх үүсвэр: ГЕГ

Зураг 18. Ноолуурын экспортын нэгж үнэ

Эх үүсвэр: ГЕГ, Монголбанк

Эдийн засаг өсч байгаа ч анхаарах асуудлууд байсаар байна...

Монгол Улсын эдийн засгийн өсөлт 2018 онд сүүлийн 4 жилийн хамгийн өндөр түвшиндээ хүрч байна. Энэхүү өсөлтөд нийлүүлэлт талаас экспортын гол нэрийн барааны үнийн өсөлт, эрэлт талаас макро бодлогын

үр дүнд аж ахуйн нэгж, иргэдийн хөрөнгө оруулалт, хэрэглээний санхүүжилт нэмэгдсэнтэй холбоотой байна. Тухайлбал, 2018 онд банкуудаас олгож буй зээлийн жилийн өсөлт нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 10 нэгж орчим хувийн өндөр үзүүлэлттэй байна.

Энэ оны эдийн засгийн өсөлтийн эерэг үр дагавар нь өнгөрсөн онуудтай харьцуулахад ажилгүйдлийн түвшний бууралт, дундаж цалингийн өсөлт, зээлийн эргэн төлөлтийн хэмжээ нэмэгдэж байгаагаар харагдаж байна. Эдийн засгийн таатай үзүүлэлтүүд гарч, өрхүүдийн орлого нэмэгдсэнээр хэрэглээний зардлууд болох хэрэглээний импорт, гадаад улсруу хийх аялал, жуулчлал, хэрэглээний зээлийн өсөлтүүд бий болж байна.

Гэхдээ гадаад орчны өөрчлөлтөөс өндөр хамааралтай хэвээр байгаа үед эдгээр эерэг өөрчлөлтийг хамгаалж урт хугацааны тогтвортой байдлыг хадгалахын тулд улс төрийн тогтвортой байдлыг хангаж тодорхой бус байдлыг бууруулах, төсөв, мөнгөний бодлогыг урт хугацаанд чиглүүлж хөрөнгө оруулагчид, хэрэглэгчдийн итгэлийг сэргээх нь чухал асуудал хэвээр байна.

МОНГОЛБАНКНЫ ЭРДЭНЭСИЙН САНГААС

**БОГД ХААНД ӨРГӨСӨН
АЛТАН НАВЧИТ ӨРГӨМЖЛӨЛ
ХОСГУЙ ҮНЭТ**
1915 он
Жин: 11235.0 гр
22.5 x 9.3 см
17 алтан хуудас



Богд хаанд ламын алтан тамгын хамт энэхүү алтан навчит өргөмжлөлийг билгийн тооллын 1915 оны хаврын сүүл сарын арван нэгэнд өргөн барьжээ. Өргөмжлөлийн үгийг алтан хуудас дээр монгол, түвэд хэлээр сийлэн бичиж улаан шунхаар тодруулжээ.

Алтан навчит өргөмжлөлийн монгол бичгийн сийрүүлгээс...

"Шашин төрийг хослон баригч, Наран гэрэлт түмэн наст Богд эзэн хааны зарлиг, Би тэнгэрийн цагийг дагаж, төр шашныг хослон барьж Монгол улсыг жолоодон тогтоохуй дор үнэнээр тус хийж чадагчдыг хэтэрхийеэ эрхэмлэх бөгөөд, эн тэргүүн өргөмжилбөөс зохих Жавзандамба лам болбоос эртний Мин улсын цаг Их Юань улсын

Тайцу хааны үе, Халхын Очирай бат Түшээт сайн хан Гомбодоржийн гэрт хувилгаан гарч, бурханы шашныг дэлгэрүүлэн, хамаг амьтныг гийгүүлж, Халхын олон монголчуудыг тэргүүлэн авч, манж монголыг найралдуулан, гавьяа байгуулсан учирт, умар зүгийн амьтны итгэл, номын Богд хэмээн алтан тамга, алтан навчит өргөмжлөлийн зэрэг зүйл бүр ёслолын юм шагнагдаж, Манж эзэн лугаа нэгэн суурин дор суух зэргээр маш өргөмжлөгдсөн анхан төрлийн Өндөр Богдоос эхлэн төрөл тутам бэлгэ билэг лүгээ төгөлдөр судар тарнийн шашныг мандуулж, амьтныг жаргуулсан тус эрдэм зарлигийн ач хязгаарлашгүй буй..."



МОНГОЛБАНК СУДАЛГАА, СТАТИСТИКИЙН ГАЗАР



ССГ нь макро эдийн засгийн тэр дундаа мөнгөний бодлого болон санхүүгийн тогтвортой байдлыг хангахад чиглэсэн бодлогын шийдвэрт дэмжлэг үзүүлэх судалгааны ажил хийх, Монгол улсын мөнгө, санхүүгийн болон гадаад секторын статистикийг олон улсын стандарт, аргачлалын дагуу нэгтгэн боловсруулж, олон нийтэд түгээх үндсэн чиг үүрэгтэй.

1. Судалгаа, шинжилгээний ажлаар бодлогын шийдвэр гаргалтад дэмжлэг үзүүлэх.



- Мөнгөний бодлогын шийдвэр гаргалтад дэмжлэг үзүүлэхүйц бодлогын суурь судалгаа болон түүвэр судалгааны ажил хийж гүйцэтгэх.
- Төв банкнаас гадна макро эдийн засаг болон санхүүгийн тогтвортой байдалтай холбоотой бодлогын шийдвэр гаргагч төрийн байгууллагуудад цаг үеийн асуудлаарх бодлогын санал, зөвлөмжийг агуулсан танилцуулга, судалгааны ажлуудыг боловсруулж, тухай бүр хүргүүлэх.
- Төв банкны бодлогын арга хэмжээ, хийгдсэн судалгааны үр дүн болон цаг үеийн тулгамдсан асуудлын хүрээнд чуулган, хурал, хэлэлцүүлгийг тогтмол зохион байгуулах замаар олон нийтэд таниулан сурталчилах.

2. Эмпирик судалгаа болон түүнд ашигладаг арга хэрэгслийг олон улсын жишигт нийцүүлэн хөгжүүлэх.



- Төв банкны судалгааны ажлуудыг олон улсын нэр хүнд бүхий сэтгүүлүүдэд хэвлүүлэх.
- Олон улсын эдийн засгийн судлаачид өргөнөөр ашиглах эконометрикийн програм хангамжуудыг хийж гүйцэтгэх, олон улсын болон дотоодын судалгаа, шинжилгээний байгууллагуудтай хамтран ажиллах.

Статистикийн хувьд дараах үйл ажиллагааг гүйцэтгэж байна:



- Монголбанкнаас олон нийтэд мэдээлдэг статистик мэдээллийг нэгтгэн боловсруулахтай холбоотой журам, заавар, аргачлал, тайлан мэдээ, бүртгэлийн маягтыг шаардлагатай тухай бүр шинэчлэн батлуулж мөрдөх.
- Үндсэн статистик мэдээллээр танилцуулга тойм бэлтгэн, гаргах.
- Статистикийн чанар, хамрах хүрээ, хүртээмжийг сайжруулах ажлыг зохион байгуулах.
- Түүвэр судалгаа явуулж, үр дүнг тайлагнах, түүвэр судалгааны шаардлагатай үзүүлэлтүүдийг статистик мэдээлэлд тусгах замаар статистикийг сайжруулах арга хэмжээ авах.
- Статистик, тайлан мэдээллийг хэрэглэгчдэд илүү хүртээмжтэй байлгах, ашиглахад хялбар болгох чиглэлээр тогтмол хөгжүүлэх.



Б.ХҮСЛЭН: ТӨВ БАНКНЫ СУДАЛГАА НЬ МАКРО ЭДИЙН ЗАСАГ, САНХҮҮГИЙН ТОГТВОРТОЙ БАЙДЛЫГ ХАНГАХАД БОДЛОГЫН ТОМООХОН ДЭМЖЛЭГ БОЛДОГ

Уншигч танд энэ удаа Монголбанкны Судалгаа статистикийн газрыг танилцуулахаар тус газрын Судалгааны хэлтсийн эдийн засагч Б.Хүслэнтэй ярилцсанаа толилуулж байна.

Ойрын үед ямар судалгаан дээр төвлөрч байна вэ?

Ойрын хугацаанд гэвэл мөнгөний бодлогын эдийн засагт үзүүлэх нөлөөг тогтоох, гадаад худалдааны бодлогод анхаарах асуудлууд болон эдийн засгийн мөчлөгийг оновчтой тодорхойлохтой холбоотой судалгааны ажлууд дээр илүү төвлөрч байна. Тухайлбал Судалгаа, статистикийн газар (ССГ)-ын Судалгааны хэлтэс (СүХ)-ийн захирал Л.Даваажаргалтай хамтран бичсэн “A Factor Augmented Vector Autoregressive (FA-VAR) approach for Monetary Policy: Replication of the empirical results in Measuring the effects of Monetary Policy” ажлыг хийж Journal of Applied Econometrics хэмээх эдийн засгийн чиглэлээр эхний 25-т эрэмбэлэгддэг олон улсын сэтгүүлд 2018 оны 11-р сард хэвлүүлээ. Мөн эдийн засгийн мөчлөгийг

тодорхойлоход ашиглагддаг BVAR алгоритмыг Л.Даваажаргал захиралтай хамтран EViews програм дээр хийх заавар бүхий блогийг тус програмын цахим сайтад 2018 оны 9-р сард байршуулсан. Яг одоо бол “Мөнгөний бодлогын шилжих механизмын асуудлууд: Вектор Авторегрессив (VAR)” судалгааны ажил дээр ажиллаж байна. Мөн Дэлхийн банкны төслийн зөвлөлтэй хамтран “Банкны салбарын зардал, ашгийн үр ашгийн шинжилгээ” судалгааны ажлыг боловсруулж байна.

Сонирхолтой юм. Баяр хүргэе! Чиний хувьд мөнгөний бодлогод яг тусгалаа олсон ямар том судалгаан дээр ажилласныг тодруулмаар санагдлаа.

Баярлалаа. Бодлогын шийдвэр гаргалтад нөлөө үзүүлэхүйц томоохон хэмжээний судалгааны

ажлуудыг хувь судлаач гэхээс илүүтэйгээр судалгааны баг хамтран боловсруулдаг. ССГ-ын судлаачдын багийн онцлох ажлуудыг энд дурдаж болно. Тухайлбал, “Арилжааны банкуудын зээл болон хадгаламжийн хүүнд нөлөөлж буй хүчин зүйлс”, “Монголын эдийн засаг дахь зээлийн өндөр хүүний оньсогыг тайлах нь”, миний бие болон Г.Мөнхбаяр нарын “Зээлийн хүүний харьцуулсан судалгаа” зэрэг судалгааны ажлуудын үр дүнд үндэслэн “Зээлийн хүүг бууруулах стратеги 2018-2023” бодлогын баримт бичиг, түүнийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулж, Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөл (СТБЗ)-өөр батлуулсан. Тус стратегийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний дагуу СТБЗ-ийн гишүүн байгууллагууд болон Засгийн газрын яамд, агентлагууд

зээлийн хүүг бууруулахтай холбоотой ажлуудыг хийж эхлээд байна. Түүнчлэн мөнгөний бодлогын шийдвэр гаргалтын суурь шинжилгээнд ашиглагддаг иргэд, аж ахуй нэгж болон шинжээчдийн инфляцийн хүлээлтийн талаарх түүвэр судалгааг ССГ-ын зүгээс улирлын давтамжтай хийж бодлогын шийдвэр гаргагчдад танилцуулдаг. Мөн манай газрын зүгээс хийж гүйцэтгэсэн “Төв банкны алдагдлыг бууруулах стратеги, хэрэгжүүлэх арга хэмжээ” судалгааны ажлын үр дүнг суурь болгон Монголбанкны дүрмийн санг нэмэгдүүлсэн. Төв банкнаас гадна бодлогын шийдвэр гаргагч албан тушаалтан, төрийн байгууллагуудад цаг үеийн асуудлаарх бодлогын санал, зөвлөмжийг агуулсан танилцуулга, судалгааны ажлуудыг тухай бүр хүргүүлж байна. Жишээлбэл, “Экспортыг дэмжих стратеги”, “Монгол Улсын гадаад худалдааны бодлогод анхаарах асуудлууд”, “Алтны олборлолтыг дэмжих төрийн өмчит компани байгуулах боломж”, “Экспортыг дэмжих санхүүжилтийн схемийн төсөл” зэрэг судалгааны ажил, танилцуулга, төсөл зэргийг боловсруулан Улсын Их Хурал, Засгийн газар болон агентлагууд, бусад холбогдох газарт хүргүүлсэн.

Төв банкны судалгаанууд мөнгөний бодлогоос гадна ямар зорилго үүрэгт чиглэсэн байдаг талаар сонирхуулаач?

Аливаа улсын төв банкны дэргэд судалгааны том институци байдаг. Энэ утгаараа төв банкны судалгааны ажлууд нь Макро эдийн засгийн тэр дундаа мөнгөний бодлого болон

санхүүгийн тогтвортой байдлыг хангахад чиглэсэн бодлогын шийдвэрт дэмжлэг үзүүлэх зорилготой байдаг. Энэ хүрээнд бодлогын суурь судалгаа болон эмпирик судалгааг хөгжүүлэх, судалгаа, шинжилгээний үр дүнд үндэслэсэн бодлогын зөвлөмжүүд боловсруулах, тодорхой судалгааны ажлуудыг хэвлэн нийтлүүлэх, илтгэл хэлбэрээр хурал, зөвлөгөөнд танилцуулах, зөвлөмж байдлаар холбогдох байгууллагуудад хүргүүлэх зэрэг чиг үүргийг хэрэгжүүлж байна.

Судалгаа хийгээд явж байх үед чинь бодит амьдрал дээрх дүр зураг чиний хувьд хэрхэн буудаг вэ. Энэ тухай сэтгэгдлээ хуваалцахыг зөвшөөрнө үү.

Эдийн засгийн судалгаа шинжилгээний ажлын нэн тэргүүний зорилго нь бодит амьдрал дээрх дүр зургийг шинжлэх ухааны үндэслэлтэйгээр тайлбарлан шинжилж түүн дээрээ үндэслэн дүгнэлт өгөх гэж ойлгодог. Бодит байдлыг эдийн засгийн загвар, аргачлалд 100 хувь дүрслэн харуулах боломжгүй хэдий ч бодит байдалд нийцтэй байдлыг хамгийн өндөр байлгахад судалгааны зорилго оршиж байдаг. Ялангуяа орчин үеийн эдийн засгийн онолын болон эконометрикийн арга зүй хурдацтай хөгжиж, бодит байдлыг тайлбарлах чадамж сайжирч байгааг онцлох нь зүйтэй болов уу. Энэ ч утгаараа миний хувьд бодит амьдрал дээрх дүр зургийг судалгааны ажлын загвартаа бүрэн тусгахыг хичээдэг. Судалгааны ажлын үр дүн маань

бодит байдалд бодлогын шийдвэрт тусгалаа олж, дэмжлэг үзүүлдэг гэдэгт итгэж байна.

Танай газраас гаргаж байгаа сар бүрийн статистикийн дүн манай улс орны нөхцөл байдлыг хэрхэн илэрхийлж буйг хэрхэн дүгнэх вэ?

Судлаач хүний хувьд бүхий л төрлийн статистик, тоо мэдээлэл анхаарал татахуйц, сонирхолтой байдаг. Тэдгээр статистик, тоон мэдээллийг ашиглах эрэлтийг байнга бий болгож байдаг. ССГ нь мөнгө, санхүүгийн салбар, гадаад сектортой холбоотой чухал статистик, тоон мэдээллийг холбогдох байгууллагуудын тайлан мэдээг сар, улирлын давтамжтайгаар тогтмол авах, түүвэр судалгаа явуулах зэрэг аргаар авч боловсруулдаг. Үзүүлэлтүүдийн статистикийг ажиглах замаар эдийн засгийн хөгжил, дэвшилтэй холбоотой асуудлыг шууд дүгнэх нь судалгаа, шинжилгээний чиглэлд арвин туршлагатай, өргөн мэдлэгтэй хүний л хийж чадах зүйл болов уу. Миний хувьд статистик тоо мэдээллээс дараагийн судалгаа, шинжилгээний сэдвийг л тодорхойлдог. Харин тухайн сэдэвтэй холбоотой статистик, тоон мэдээллийг ашиглан эдийн засгийн аргачлалаар дүн шинжилгээ хийсний дараа эдийн засагт гарч буй өөрчлөлтийн талаар илүү дэлгэрэнгүй дүгнэлтүүдийг өгөх боломжтой болно. Сүүлийн статистик мэдээллүүдээс харахад эдийн засагт сэргэлт гарч байна. Гэхдээ төлбөрийн тэнцэл хүндрэх, чанаргүй зээл өсч байгаа зэрэг

Бодлогын шийдвэр гаргалтад нөлөө үзүүлэхүйц томоохон хэмжээний судалгааны ажлуудыг хувь судлаач гэхээс илүүтэйгээр судалгааны баг хамтран боловсруулдаг. ССГ-ын судлаачдын багийн онцлох ажлуудыг энд дурдаж болно. Тухайлбал, “Арилжааны банкуудын зээл болон хадгаламжийн хүүнд нөлөөлж буй хүчин зүйлс”, “Монголын эдийн засаг дахь зээлийн өндөр хүүний оньсогыг тайлах нь”, миний бие болон Г.Мөнхбаяр нарын “Зээлийн хүүний харьцуулсан судалгаа” зэрэг судалгааны ажлуудын үр дүнд үндэслэн “Зээлийн хүүг бууруулах стратеги 2018–2023” бодлогын баримт бичиг, түүнийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулж, Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөл (СТБЗ)–өөр батлуулсан.]]

ирээдүйд эрсдэл бий болгож болзошгүй хүчин зүйлүүд байна.

Танай газраас макро түвшний томоохон хэлэлцүүлгийг олон нийтийн дунд зохион байгуулдаг шүү дээ. Жишээлбэл, Улаанбаатарын зөвшилцөл, Гадаад худалдааны бодлогын асуудал, Зээлийн хүүг бууруулах стратеги гэх мэтчлэн. Өөр бодлогын ямар асуудлуудад анхаарлаа хандуулж байна вэ?

ССГ-ын зүгээс бодлогын шийдвэр гаргалтад дэмжлэг үзүүлэх ажил нь зөвхөн судалгааны ажил хийх байдлаар хязгаарлагддаггүй. Олон нийтэд Төв банкны бодлогын арга хэмжээ, хийгдсэн судалгааны үр дүнг таниулан сурталчлах, эрдэмтэн, судлаачдын саналыг авч бодлогын шийдвэр гаргалтад тусгах, төрийн байгууллагуудын бодлогын нягт уялдаатай байдлыг бий болгох зорилгоор чуулган, хурал, хэлэлцүүлгийг цаг үеийн тулгамдсан асуудлын хүрээнд тогтмол зохион байгуулж байна. Зөвхөн 2018 онд гэхэд нийт 14 хурал, хэлэлцүүлгийг төрийн болон хувийн байгууллагын төлөөлүүд, эрдэмтэн судлаачид болон олон нийтийг өргөнөөр хамруулан 2000 гаруй хүнийг оролцуулан зохион байгуулсан. Эдгээрээс онцлох үйл явдлууд нь таны дурьдсанчлан “Эдийн засгийн бодлогын анхдугаар чуулган: Эдийн засгийн бодлогын сорилт, чиг хандлага”, “Улаанбаатарын зөвшилцөл” хэлэлцүүлэг, “Зээлийн хүүг бууруулах стратеги” зэрэг хэлэлцүүлэг байсан. Эдгээрээс гадна “Макро эдийн засгийн бодлогын

шинэ хандлагууд”, “Эдийн засгийн өнөөгийн байдал цаашдын чиг хандлага” зэрэг асуудлуудад анхаарал хандуулж холбогдох хурал хэлэлцүүлгүүдийг зохион байгууллаа.

Эцэст нь сонирхоход чиний хувьд ирэх жил ямар судалгаа хийхийг хүсч байна вэ. Мөн танай хэлтсээс шинээр ямар төрлийн судалгаа хийхээр зорьж буй тухай сонирхуулна уу?

Миний хувьд ирэх жил “Чөлөөт худалдааны хэлэлцээрийн эдийн засагт үзүүлэх нөлөө” сэдвээр судалгаа хийнэ. Гадаад харилцааны яамнаас Хятад болон Өмнөд Солонгос улстай чөлөөт худалдааны хэлэлцээр хийхээр ажиллаж байгааг мэдэгдсэн. Эдгээр улстай чөлөөт худалдааны хэлэлцээр хийх нь манай улсын гадаад худалдааны нөхцөл байдалд ашигтай эсэхийг эдийн засгийн загварчлалд үндэслэн тодорхойлох нь чухал юм. Манай ССГ-ын зүгээс дараа жил “Монголбанкны интервенцийн валютын зах зээлд үзүүлэх нөлөө”, “Макро бодлогын өрхийн хэрэглээний бүтцэд үзүүлэх нөлөө”, “Төсвийн бодлогын инфляцид үзүүлэх нөлөө”, “Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний өөрчлөлтийн эдийн засагт үзүүлэх нөлөө”, “Цахим санхүүгийн хэрэгслүүдийн эдийн засагт үзүүлж буй нөлөө”, “Шатахууны үнийн эдийн засагт үзүүлэх нөлөө”, “Орлогын тэгш бус байдлын асуудлууд” зэрэг судалгааны ажлуудыг хийхээр төлөвлөж байна.

Ярилцсанд баярлалаа.



МӨНГӨНИЙ БОДЛОГЫН МЭДЭГДЭЛ

Огноо: 2018/12/14

БОДЛОГЫН ХҮҮГ ХЭВЭЭР ХАДГАЛАХ ТУХАЙ

Дугаар: 2018/05

Огноо: 2018 оны 12 дугаар сарын 14-ний өдөр

Монголбанкны Мөнгөний бодлогын хорооны 2018 оны 12 дугаар сарын 14-ний ээлжит хурлаар Бодлогын хүүг 11 хувьд хэвээр хадгалах шийдвэр гаргалаа.

Жилийн инфляци 2018 оны 11 дүгээр сард улсын хэмжээнд 8.1 хувьтай байна. Нийлүүлэлтийн шалтгаанаар мах, шатахуун, хатуу түлш зэрэг барааны үнэ өссөн нь инфляцид голлон нөлөөлөв. Цалин болон дотоод эрэлтийн өсөлтөөр дамжин эрэлтийн шалтгаантай хүчин зүйлсийн инфляцид үзүүлэх нөлөө ирэх онд нэмэгдэхээр байна.

Эдийн засгийн өсөлт алгуур нэмэгдэж буй хандлага ирэх онд хадгалагдахаар байна. Хэдийгээр гадаад орчны тодорхой бус байдал үргэлжилж байгаа боловч энэ оны эхний 11 сарын байдлаар худалдааны тэнцэл ашигтай, төлбөрийн тэнцлийн алдагдал бага байгаа нь төгрөгийн ханш тогтворжих суурь болж байна. Мөнгөний бодлогын хороо инфляцид нөлөөлж буй хүчин зүйлс, тэдгээрийн цаашдын төлөв, бизнесийн идэвхжлийг харгалзан бодлогын хүүг энэ удаад хэвээр хадгалах нь зүйтэй гэж үзэв.

Мөнгөний бодлогын хорооны энэ удаагийн шийдвэр нь инфляцийг дунд хугацаанд зорилтот түвшний орчимд тогтворжуулах зорилттой нийцтэй бөгөөд макро эдийн засгийн дунд хугацааны тогтвортой байдлыг хадгалахад чиглэж байна.

Хорооны хуралдааны хураангуй тэмдэглэлийг хоёр долоо хоногийн дараа Монголбанкны цахим хуудаст байршуулна.

МӨНГӨНИЙ БОДЛОГЫН ХОРОО



МОНГОЛБАНКНЫ ХЭВЛЭЛИЙН БАГА ХУРЛААС (2018.12.14)

Мөнгөний бодлогын хороо 12 дугаар сарын 14-ний өдөр хуралдаж, бодлогын хүүг 11 нэгж хувьд хэвээр хадгалах шийдвэр гаргалаа. Мөнгөний бодлогын шийдвэрийг танилцуулах хэвлэлийн бага хурлын үеэр төв банкны удирдлагууд сэтгүүлчдийн асуултад хариулж, мэдээлэл өглөө.

Блүүмбэрг ТВ:

Инфляци улсын хэмжээнд 8.1%, Улаанбаатар хотод 9.3%-д хүрч өссөн байна. Улаанбаатар хотын инфляцийн өсөлтийг та бүхэн Төв банкны зорилтыг давсан гэж үзэж байна уу? Мах, шатахуун, түлшний үнээс өөр ямар хүчин зүйл инфляцийн өсөлтийг бүрдүүлж байгаа вэ?

Тэргүүн Дэд Ерөнхийлөгч **О.ЭРДЭМБИЛЭГ:**

Төв банкны хувьд суурь инфляцийг тооцдог. Өнөөдрийн нөхцөл байдлаас үзэхэд суурь инфляцид хамгийн томоохон нөлөө үзүүлж байгаа хүчин зүйл нь хатуу түлшний үнэ юм. Төрийн зохицуулалттай холбоотойгоор дөрөвдүгээр сарын 1-нээс Улаанбаатар хотод хатуу түлш оруулахыг хориглосноос нөөц бүрдүүлэлт өсч, хатуу түлшний үнэд нөлөөлсөн болов уу. Иймэрхүү улирлын шинж чанартай нөлөөлөл цаашид тодорхой хугацаанд үргэлжлэх болов уу гэсэн хүлээлттэй байна. Монголын эдийн засагт улирлын онцлог бий. Жишээлбэл, махны үнийг дурдаж болно. Нэгдүгээрт, цаг уурын нөхцөл байдал, улирлаас

хамаарч махны үнэд өөрчлөлт гардаг. Хоёрдугаарт, судалгаанаас харахад гадаад хүчин зүйл, тэр дундаа БНХАУ руу махны нийлүүлэлт хийж байгаа нь манай дотоод зах зээлийн махны үнэд нөлөөлж байна.

Мөнгөний бодлогын газрын захирал **Б.БАЯРДАВАА:**

Улаанбаатар хотын инфляци 9.3 хувьтай байгааг бүрэлдэхүүн хэсгээр нь задалъя. Хатуу түлшний хувьд зөвхөн 11 дүгээр сард гэхэд 13.8 хувиар үнэ өссөн байна. Энэ нь Улаанбаатар хотын инфляцийн өсөлтийн 2.2 нэгж хувийг дангаараа тайлбарлаж байгаа юм. Мөн 9.3 хувийн инфляцийн 1.3 нэгж хувь нь махны үнэтэй холбоотой. Дээр нь бензин, шатахууны үнэ дэлхийн зах зээл дээр 2016 оны 1-р улирлаас эхлэн зогсолтгүй өссөн. Үүнийг дагаад Монгол Улс ОХУ-аас импортолж байгаа шатахууны хилийн үнэ өсч, улмаар дотоодын шатахууны үнэд нөлөөлж байна. Энэ өөрчлөлт нь Улаанбаатар хотын инфляцийн 1.5 нэгж хувийг бүрдүүлж байна. Нэгтгээд үзэхэд энэ гурван бараа, бүтээгдэхүүний үнийн өөрчлөлт нь нийслэл хотын инфляцийн 5%-ийг тайлбарлаж үнийн өсөлт нь инфляцид хүчтэй

нөлөөлжээ.

Төв банк суурь инфляци гэдэг үзүүлэлтийг хардгийн гол зорилго нь эрэлт талаасаа инфляци цаашид өдөөгдөж, өсөлт нь нэмэгдэх эрсдэл байна уу гэдгийг харах ач холбогдолтой. Инфляцийн сагснаас улирлын болон нийлүүлэлтийн шинжтэй хэлбэлздэг буюу макро эдийн засгийн үзүүлэлтүүдтэй төдийлөн хүчтэй хамаарахгүйгээр үнэ нь хөдөлдөг бараа бүтээгдэхүүнийг хассанаар ерөнхий тренд, хандлагыг тодорхойлж, суурь инфляцийг тооцдог. Үндэсний статистикийн хорооноос гаргаж байгаа инфляци нь бидний хараад байгаа суурь инфляцийг зарим талаар төдийлөн илэрхийлж чаддаггүй. Тиймээс Төв банк өөрсдийн дотоод тооцооллыг ашигладаг. Ингээд тооцоход импортын болон холбогдох зарим бараа бүтээгдэхүүний үнэ, нэг удаагийн шинжтэй үнийг хасаад тооцоход эрэлтийн шинжтэй инфляцийн өсөлт хурдассан зүйл харагдахгүй байгаа. Хэдийгээр инфляцийн түвшин Улаанбаатарт 9.3 хувьд хүрч, өндөр байгаа мэт боловч энэ нөлөөлөл 12 дугаар сарын төгсгөлд арилах төсөөлөлтэй байгаа тул мөнгөний бодлогыг чангаруулах дарамт одоохондоо харьцангуй бага гэж харж байна.

Он гараад цаашдын эдийн засгийн нөхцөл байдлыг харгалзан үзээд, шинэ мэдээллүүдэд үндэслэн Мөнгөний бодлогын хорооны шийдвэрийг гаргана. Тэр үед бодлогын хүүг өөрчлөх нөхцөл үүсэхийг үгүйсгэхгүй.

Блүүмбэрг ТВ:

Төлбөрийн тэнцлийн алдагдал багассан байна. Хөгжлийн банкны бондын санхүүжилт орж ирснээр энэхүү бууралт үүссэн гэж байгаа. Тэгэхээр, төлбөрийн тэнцлийг сайжруулахад цаашид юун дээр анхаарвал зохих вэ. Ялангуяа, Засгийн газрын зүгээс хэрхэх нь зүйтэй вэ?

Тэргүүн Дэд Ерөнхийлөгч О.ЭРДЭМБИЛЭГ:

Өнөөдрийн байдлаар дотоод эрэлтийн тодорхой хэмжээний дарамт арилжааны банкуудаас эдийн засагт нийлүүлж буй зээлийн хэмжээгээр өдөөгдсөн. Үүнийг эерэг талаас нь харвал, эдийн засгийн идэвхжилтэй холбоотой. Гэхдээ нөгөө талд Монголбанк арилжааны банкуудаас эдийн засагт нийлүүлж буй зээлийн бүтцэд анхаарч байгаа. Энэ агуулгаараа бид зургаа болон есдүгээр сард макро зохистой бодлогын шийдвэрийн хүрээнд дараалсан хоёр удаагийн арга хэмжээ авсан.

Үүгээр хэрэглээний зээлээр дамжиж импорт өдөөгдөх нөхцөл байдлыг хязгаарлах, аж ахуйн нэгжүүдэд олгох зээлийн нийлүүлэлтийг нэмэгдүүлж, хувийн хэвшлийг дэмжихийг зорьсон. Мэдээж, үүнээс гадна дотоод эрэлтэд төсвийн бодлого нөлөөлдөг. Энэ бүх асуудлыг бид Мөнгөний бодлогын хорооны хурлаараа ярилцсан. Та бүхний мэдэж байгаачлан Монголын эдийн засагт улирлын онцлог гэж бий. Арилжааны банкууд дээр бизнесийн зээлийн судалгаа идэвхжиж эхлэх хугацаа нь үндсэндээ жил бүрийн хоёрдугаар сар байдаг. Улмаар дөрөвдүгээр сараас бизнесүүд идэвхжиж эхэлдэг. Тэрнээс өмнө мэдээж Мөнгөний бодлогын хороо хуралдана. Яг эдийн засаг талаас нь яривал төсвийн үржүүлэгч гэж ойлголт бий. Өөрөөр хэлбэл, төсвийн дотоод эрэлтэд үзүүлэх нөлөөлөл юм. Энэ бүгдийг харах хэрэгтэй.

Судалгаа, статистикийн газрын захирал Д.ГАН-ОЧИР:

Мөнгөний бодлогын мэдэгдэлд дурдсанчлан гадаад худалдааны тэнцэл 636.9 сая ам.долларын ашигтай байгаа. Төлбөрийн тэнцлийн хувьд 51 сая ам.долларын алдагдалтай байна. Том зургаар нь харвал, өнөөдөр Монгол Улсаас гарч байгаа валютын урсгал 51 сая ам.доллар байна. Валютын зах зээл дээр хэт хомсдол үүсч, ханш сулрах, огцом хэлбэлзэл үүсэх дарамт ерөнхий зургаараа харагдахгүй байна. Макро эдийн засгийн суурь үзүүлэлтийн хувьд инфляци бага зэрэг өссөн, гэхдээ энэ нь түр зуурын хүчин зүйлээс хамааралтай. Үүнийг эс тооцвол бусад макро үзүүлэлтүүд тухайлбал зээл, мөнгө, эдийн засгийн өсөлт тогтвортой, эдийн засгийн эерэг момент дээр байна. Тиймээс валютын зах дээр том цочрол үүсэх дарамт бага байна.

Харин ирээдүйд Засгийн газраас анхаарах шаардлагатай зүйлс бий. Монголбанкны зүгээс холбогдох зөвлөмж, саналыг Засгийн Газарт хүргүүлдэг. Мэдээж өнөөгийн байдлаар нүүрсний экспортыг дэмжих, тэр дундаа хил нэвтрүүлэхийг Засгийн газрын түвшинд, дипломат арга замаар анхаарч, харилцах зүйл байна. Мөн Монгол Улсад валютын орох урсгалыг бүрдүүлдэг гол хэсэг болох гадаадын шууд хөрөнгө оруулалтыг дэмжих хэрэгтэй. Одоогийн байдлаар 1.44 тэрбум ам.долларын гадаадын шууд хөрөнгө оруулалт энэ онд манайд орж ирсэн. Цаашид “Таван Толгой”

ээрэг ГШХО-ыг дэмжих төслүүд дээр идэвх чармайлт гарган, үргэлжлүүлэх шаардлага бий. Түүнчлэн, төсвийн зарцуулалт тал дээр импортын дарамтыг бий болгох асуудал анхаарал татаж байна. Тэгэхээр төсвийн зарцуулалт, хөрөнгө оруулалтын хуваарийг гаргахдаа төлбөрийн тэнцэлд ирэх дарамтыг харгалзаж үзэх, цаг хугацааны хувьд тархаах асуудлыг анхаараач гэсэн зөвлөмжийг Засгийн газарт хүргүүлж байгаа. Засгийн газрын зүгээс эдгээр зөвлөмжийг харгалзан үзвэл валютын орж ирэх урсгал, валютын захын тогтвортой байдалд үзүүлэх дэмжлэгүүд эерэг байх хүлээлттэй байна.

МОНЦАМЭ:

Валютын ханш сүүлийн үед суларч байна. Валютын ханшийн инфляцид ирэх нөлөө хэр өндөр байгаа вэ?

Нөөцийн Удирдлага, Санхүүгийн Зах зээлийн газрын захирал **А.ЭНХЖИН:**

Ерөнхийдөө эдийн засгийн суурь нөхцөл байдлыг авч үзвэл ханшид огцом өөрчлөлт гарах нөхцөл үүсээгүй. Төлбөрийн тэнцлийн хувьд энэ оны эхний 10 сарын байдлаар дээр дурдсанчлан 51 сая ам.долларын алдагдалтай байна. Манай гадаад валютын албан нөөцийн мөн үед 3.4 тэрбум ам.долларт хүрсэн нь сүүлийн 6 жилийн хамгийн дээд төвшинд хүрсэн үзүүлэлт юм. Төлбөрийн тэнцлийн алдагдал буурсан, ГВАН харьцангуй өндөр түвшинд хүрсэн, нөгөө талаас инфляци нийлүүлэлтийн гаралтай зарим цөөн төрлийн бараа бүтээгдэхүүний үнийн өсөлтөөс хамаарч 11 сард нэмэгдсэн ч гэсэн цаашид тогтвортой байх нөхцөлд ханшид огцом өөрчлөлт орохгүй гэж харж байгаа.

Эрэлт нийлүүлэлтийн шинжтэй, түр зуурын огцом хэлбэлзэлд Монголбанкнаас тухай бүрд нь оролцож, валютын захад валют нийлүүлэх үүргээ биелүүлж байна. Энэ оны эхнээс хойш Төв банкнаас нийт 1.2 тэрбум ам.долларыг валютын захад дуудлага худалдаа хэлбэрээр нийлүүлсэн. Ялангуяа 11 дүгээр сар гарснаас хойш Төв банкнаас 425 сая гаруй ам.долларыг захад нийлүүлээд байна. Сүүлийн үеийн буюу 11 дүгээр сар гарснаас хойших өөрчлөлтийг Төв банкны зүгээс түр зуурын шинжтэй буюу улирлын гаралтай, эрэлт нийлүүлэлтийн зөрүүгээс үүссэн ханшийн хөдөлгөөн хэмээн харж байгаа. Цаашид ханш тогтвортой байх хүлээлттэй байна.

Монгол ТВ:

Улс төрийн тогтворгүй байдал ханшид тодорхой хэмжээнд нөлөөлж байгаа. Жишээ нь Засгийн газрыг огцруулах талаар хэлэлцэх үед ханшид өөрчлөлт орсон. Цаашид эдийн засагт бага ч гэсэн гэгээлэг зүйл харагдаж, ханш буурах хандлага байна уу?

НУСЗЗГ-ын захирал А.ЭНХЖИН:

11 дүгээр сар гарснаар үүссэн нөхцөл байдалд нэгдүгээрт, мэдээж улс төрийн нөхцөл байдал нөлөөлсөн. Мөн манай нүүрсний экспортын бараг 50 гаруй хувь нь гардаг хилийн боомт дээр саатал үүссэнээр хилээр нэвтрэх тээврийн хэрэгслийн тоо огцом буурсан. Хэдийгээр 2016 оноос хойш манай эдийн засгийн нөхцөл байдал сайжирсан ч, бид ОУВС-ийн Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөрийг 2020 хүртэл үргэлжлүүлнэ. Тиймээс хөтөлбөр хэрэгжихийн тулд Засгийн газрын тогтвортой, төрийн бодлого анх тохиролцсон чиглэлдээ үргэлжлэх шаардлагатай. Тэгэхээр Засгийн газарт өөрчлөлт орох, улс төрийн нөхцөл байдал тодорхойгүй болох тохиолдолд гадаад болон дотоод эрсдэл, тодорхой бус байдал тэр хэмжээгээр нэмэгдэнэ. Энэ нь ханшинд дарамт үүсгэж байгаа.

Монголбанкны зүгээс 2019 онд тус хөтөлбөрийг цаашид тууштай үргэлжлүүлээд явна. Бид банкны салбарын бүтцийн өөрчлөлт болон эдийн засагт хэрэгжүүлж байгаа бодлогоо үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ. Мөн банк санхүүгийн салбарын хууль эрх зүйн шинэчлэлийг үргэлжлүүлнэ. Иймд Төв банкны зүгээс цаашид тогтвортой, тодорхой байдлыг бий болгоно гэж харж байна. Засгийн газрын зүгээс ч хөтөлбөрийн хүрээнд хүлээсэн үүргээ цаашид тууштай үргэлжлүүлж, донор байгууллагуудаас хийх санхүүжилтүүдийг цаг тухайд нь аваад явбал 2019 онд эдийн засагт томоохон цочрол үүсэхээргүй харагдаж байна. Монголбанкны зүгээс 2019 онд валютын ханш харьцангуй тогтвортой байж, энэ чинээгээр эдийн засаг мөн тогтвортой өсөх байх гэсэн хүлээлттэй байгаа. Төсөв дээр ирэх оны эдийн засгийн өсөлтийг 8 хувь Монголбанкны зүгээс 6.3 орчим хувь байна гэсэн хүлээлттэй байгаа. Тэгэхээр эдийн засгийн өсөлт 2019 онд хадгалагдана. Ханшийн хувьд бидний зүгээс цаашид ийм байна гэсэн чиглэл, мэдээлэл шууд өгөх боломжгүй.

МӨНГӨ, САНХҮҮГИЙН СТАТИСТИК


%

ХҮҮ

ИПОТЕКИЙН ЗЭЭЛ


ГАДААД СЕКТОРЫН СТАТИСТИК

Зураг 1.1. Мөнгөний нийлүүлэлтийн жилийн өсөлтийн бүтэц



- **M2 мөнгөний жилийн өсөлт 25.8%** -д хүрч **18.7** их наяд **₮**-т хүрэв.
- Өмнөх сараас **1.7%**-иар буюу **318.8** тэрбум **₮**-өөр өсөв.
- Үүнээс, **M1** мөнгө **0.1%** (2.8 тэрбум **₮**), **бусад хадгаламж 2.1%** (316.0 тэрбум **₮**) –иар өссөн байна.
 - **M1** → **₮**-ийн харилцах **2.9** тэрбум **₮**-өөр буурч, хадгаламжийн байгууллагаас гадуурх мөнгө **5.7** тэрбум **₮**-өөр өсөв.
 - **Бусад хадгаламж** → **₮**-ийн хадгаламж **199.0** тэрбум **₮**-өөр, **\$**-ийн хадгаламж **187.1** тэрбум **₮**-өөр өсч, **\$**-ийн харилцах **70.0** тэрбум **₮**-өөр буурав.

Зураг 1.2. Мөнгөний үзүүлэлтүүдийн сарын өөрчлөлт, тэрбум ₮



МӨНГӨ, САНХҮҮГИЙН СТАТИСТИК


%

ХҮҮ


ИПОТЕКИЙН ЗЭЭЛ

ГАДААД СЕКТОРЫН СТАТИСТИК

Зураг 1.3. Мөнгөний нийлүүлэлтийн бүтэц



Зураг 1.4. Нийт хадгаламж



- Нийт **M2 мөнгөний нийлүүлэлтийн 51.7%**-ийг **₮**-ийн хадгаламж бүрдүүлж байгаа бол **15.7%**-ийг валютын хадгаламж, **15.2%**-ийг **₮**-ийн харилцах, **14.2%**-ийг валютын харилцах, үлдсэн **3.3%**-ийг хадгаламжийн байгууллагаас гадуурх мөнгө бүрдүүлж байна.
- Нийт хадгаламжийн хэмжээ **12.6** их наяд **₮**-т хүрснээс **84.6%**-ийг иргэдийн хадгаламж, **15.4%**-ийг байгууллагын хадгаламж бүрдүүлж байна.
- Иргэдийн хадгаламжийн **20.1%**-ийг, байгууллагын хадгаламжийн **40.7%**-ийг гадаад валютын хадгаламж бүрдүүлж байна.

МӨНГӨ, САНХҮҮГИЙН СТАТИСТИК


%

ХҮҮ

ИПОТЕКИЙН ЗЭЭЛ

ГАДААД СЕКТОРЫН СТАТИСТИК

Зураг 1.7. Зээл, зээлийн чанар



Зураг 1.8. Зээлийн үлдэгдлийн бүтэц, эдийн засгийн салбарын ангиллаар



- Нийт зээл **16.6** их наяд **₮** (**₮** зээл **13.7** их наяд **₮**, **\$** зээл **2.9** их наяд **₮**)
- Зээлийн үлдэгдэл өмнөх сараас **263 тэрбум ₮** буюу **2%**-иар өссөн.
- Хэвийн зээл өмнөх сараас **226 тэрбум ₮** буюу **2%**-иар өссөн.
- Хугацаа хэтэрсэн зээл өмнөх сараас **70 тэрбум ₮** буюу **7%**-иар буурсан.
- Чанаргүй зээл өмнөх сараас **107 тэрбум ₮** буюу **5%**-иар өссөн байна.

МӨНГӨ, САНХҮҮГИЙН СТАТИСТИК


%

ХҮҮ

ИПОТЕКИЙН ЗЭЭЛ

ГАДААД СЕКТОРЫН СТАТИСТИК


Зураг 2.1. Нийт шинээр татсан хадгаламж, хүү



Тайлант сард:

- Иргэдээс татсан ₮-ийн хадгаламжийн ЖДХ 12.2%, хувийн байгууллагаас татсан ₮-ийн хадгаламжийн ЖДХ 10.2% байна.
- Иргэдэд шинээр олгосон ₮-ийн зээлийн ЖДХ 17.4%, хувийн байгууллагад олгосон ₮-ийн зээлийн ЖДХ 17.2% байна.

Зураг 2.2. Нийт шинээр олгосон зээл, хүү



МӨНГӨ, САНХҮҮГИЙН СТАТИСТИК


%

ХҮҮ

ИПОТЕКИЙН ЗЭЭЛ

ГАДААД СЕКТОРЫН СТАТИСТИК


Зураг 2.3. Нийт хадгаламжийн үлдэгдэл, хүү



Тайлант сард:

- Иргэдийн ₮-ийн хадгаламжийн ЖДХ 12.2%, хувийн байгууллагын ₮-ийн хадгаламжийн ЖДХ 11.6%-тай байна.
- Иргэдийн ₮-ийн зээлийн ЖДХ 18.4%, хувийн байгууллагын ₮-ийн зээлийн ЖДХ 15.5%-тай байна.

Зураг 2.4. Нийт зээлийн үлдэгдэл, хүү



Тайлант сард олгосон зээл

Зураг 3.1. Тайлант сард олгосон ипотекийн зээл



Тайлант сард банкууд 957 зээлдэгчид 73.9 тэрбум ₮-ийн ипотекийн зээл шинээр олгосноос 54.7% нь хөтөлбөрийн, 45.3% нь банкуудын өөрийн эх үүсвэрээр олгосон зээл байв.

Зээлийн үлдэгдэл

Зураг 3.2. Тухайн сард олгосон ипотекийн зээлийн хүү



Тухайн сард олгосон ипотекийн зээлийн жигнэсэн дундаж хүү 10.8 хувь болж өмнөх сараас 2.4 нэгж хувиар, өмнөх жилийн мөн үеэс 0.5 хувиар тус тус буурчээ.

МӨНГӨ, САНХҮҮГИЙН СТАТИСТИК

%

ХҮҮ

ИПОТЕКИЙН ЗЭЭЛ

Б.ДАВААДАЛАЙ: ЭДИЙН ЗАСАГ ЭРГЭЭД ХҮНДРЭЛД ОРОХ МАГАДЛАЛ МАШ ОЙРХОН ГЭДГИЙГ САНАХ ХЭРЭГТЭЙ



Дэлхийн банкны эдийн засагч Б.Даваадалайтай ярилцлаа.

**2018 ОН ӨНДӨРЛӨЖ БАЙНА.
ЭНЭ ОН ЭДИЙН ЗАСАГ, БАНК
САНХҮҮГИЙН САЛБАРЫН
ХУВЬД ЯМАРХУУ ЖИЛ
БОЛЖ ӨНГӨРӨВ ГЭДГЭЭР
ЯРИЛЦЛАГАА ЭХЭЛЬЕ.**

Эдийн засагт 2018 онд нэлээд сэргэлт ажиглагдлаа. Төсөв, мөнгөний бодлогын хувьд ч бас эерэг үзүүлэлтүүд гарсныг тэмдэглэх хэрэгтэй. Тухайлбал, 2016 оны сүүлч, 2017 оны эхэн үеэс эдийн засагт нэлээд эерэг үзүүлэлтүүд ажиглагдаж эхэлсэн. Эхний шалтгаан нь манай улсын гадаад эрэлтээс ихээхэн хамааралтай байв. Ялангуяа түүхий эд буюу манай голлох түүхий эд болох нүүрсний салбарт нэлээд сэргэлт ажиглагдсан. Үнэ өндөр өссөнөөс гадна БНХАУ-

ын Хойд Солонгосоос авдаг нүүрсний импортод хязгаарлалт тавигдсан нь манай нүүрсний экспортын гадаад эрэлтийг огцом өсгөсөн. Энэ нь эдийн засгийн сэргэлтийн эхний гол шалтгаан байв. Нөгөөтэйгүүр 2017 оны 5 дугаар сараас ЗГ болон Төв банк олон улсын хөгжлийн түншүүдтэй хамтран эдийн засагт тохиргоо хийх хөтөлбөрийг хэрэгжүүлж эхэлсэн. Өнөөдрийг хүртэл зарим зүйлийг эс тооцвол хөтөлбөрийн хүрээнд төсөв, мөнгөний бодлого дээр нэлээд томоохон шинэчлэлүүд хийгдлээ гэж үзэж байна. Зарим зүйлс гэдгээ тодруулбал, төсөв болон нийгмийн халамжийн бодлогод хийх байсан 2 чухал тохиргоо хараахан хийгдэж чадаагүй. Тухайлбал, хүн

амын орлогын албан татварыг шатлалтай болгох, тэтгэврийн насыг нэмэгдүүлэх санаачилгууд харамсалтай нь хэрэгжиж чадаагүй. Энэ хоёрыг эс тооцвол бусад голлох арга хэмжээнүүд амжилттай хэрэгжсэн гэж хэлж болохоор байна. Ялангуяа төв банкны тухайд Төв банкны тухай хуулийг шинэчилсэн. Онцлох өөрчлөлт бол төсвийн шинжтэй арга хэмжээнд төв банкны оролцоог хумьсан нь нэлээд том ахиц, дэвшил болсон. Мөн банкны салбарт олон чухал хууль, журам батлагдлаа. Хамгийн гол нь банкны салбарт Активын чанарын үнэлгээ хийгдсэн. Үр дүн нь хүлээж байснаас харьцангуй нааштай гарсан. Гэхдээ уг үнэлгээний үр дүнг цаашид баталгаажуулах, банкны системд

шаардлагатай байгаа хөрөнгийн дутагдлаа амжилттай нөхөх асуудал чухал хэвээр байна.

**2018 ОНЫ ЭХЭНД ДЭЛХИЙН
БАНКНЫ ЗҮГЭЭС МОНГОЛ
УЛСЫН ЭДИЙН ЗАСГИЙН
ӨСӨЛТИЙН ТАЛААР
ТААМАГЛАЛ ДЭВШҮҮЛЖ
БАЙСАН. ТЭР ҮЕИЙН
ТӨСӨӨЛӨЛ ӨНӨӨДРИЙН
БОДИТ ГҮЙЦЭТГЭЛ ХОЁР ХЭР
ЗӨРҮҮТЭЙ БАЙНА ВЭ?**

Эдийн засгийн өсөлтийн тухайд бодит гүйцэтгэл төсөөлснөөс харьцангуй сайн байлаа. Сүүлийн 3 улирал дараалан эдийн засаг 6 хувиас давж өслөө. Дэлхийн банкны зүгээс 2018 оны эцэс гэхэд Монгол Улсын эдийн засаг 5.9 хувиар өсөх болов уу гэсэн хүлээлттэй байгаа. Эхний 3 улирлын байдлаар өсөлт 6.4 хувьтай байгаа. Оны сүүлийн улирлын гүйцэтгэлд бид бага зэргийн болгоомжтой хандаж байна. Өнгөрөгч 11 дүгээр сарын дунд үеэс эхэлсэн хил дээр үүсээд буй гацаа, улирлын шинж чанартай зарим онцлогуудаас хамаарч, эдийн засгийн өсөлт 4 дүгээр улиралд бага зэрэг саарч, оны эцэст өсөлт 5.9 хувь орчим гарах болов уу гэсэн таамаглалтай байгаа. Гэхдээ энэ бол нэлээд болгоомжтой авсан төсөөлөл гэдгийг анхаарах хэрэгтэй. Мөн энэхүү төсөөлөл нь 2017 оны сүүл, 2018 оны эхээр төсөөлж байсантай харьцуулахад нэлээд өндөр гэдгийг мөн санах хэрэгтэй. Төсвийн тухайд л гэхэд орлого эхний 11 сарын байдлаар бараг 24 хувиар давж биелээд байна. Мөн зардал талдаа энэ жил тодотгол хийгээгүй учраас зардлаа

санхүүжүүлэх хангалттай боломж, орон зай байгаа гэж харж байна. 12 дугаар сард огцом, их хэмжээний зардал гарахгүй л бол оны сүүлч гэхэд төсөв бага зэргийн ашигтай ч гарч болохоор байна. Тэгэхээр би давтаад хэлэхэд энэ оны эхэнд бидний төсөөлж байсныг бодвол төсөв, мөнгөний бодлого дээр маш олон эерэг үзүүлэлтүүд гарсан. Гэхдээ үүний нөгөө талд сөрөг үзүүлэлтүүд ч бас байгаа. Эдийн засгийн идэвхжил импортыг ихээр нэмэгдүүлж байна. Дотооддоо үйлдвэрлэл өндөр хөгжөөгүй учраас эдийн засаг сайжирч идэвхжлийн хэрээр импорт өсч байна. Импортын жилийн өсөлт нь сүүлийн 12 сарын дунджаар бараг 40 хувьтай байна. Түүнчлэн санхүүгийн секторт зээл нэлээд өсөлттэй байгаа. Ялангуяа, хэрэглээний зээл нэлээд өсөлттэй байгаа. Сүүлийн саруудыг харвал аж ахуйн нэгжүүдэд олгож байгаа зээл ч бас нэлээд өндөр өсөлт үзүүлж байна. Ийнхүү зээл болон импортын өндөр өсөлт гадаад секторын дарамтыг нэмэгдүүлж, улмаар нөөц болон ханшинд дарамт учруулах байдал сүүлийн саруудад хүчтэй ажиглагдаж байгааг анхаарах хэрэгтэй. Төв банкны зүгээс энэ оны хоёрдугаар хагаст хэрэглээний зээлийг хумих, аж ахуйн нэгжүүдэд очих зээлийг дэмжих, урамшуулах бодлогыг авч шат дараатай хэрэгжүүлж байгааг мөн дурьдах нь зөв болов уу.

**ТӨВ БАНКНЫ ХУВЬД МАКРО
ЗОХИСТОЙ БОДЛОГЫН
ШИЙДВЭРИЙН ХҮРЭЭНД
ХЭРЭГЛЭЭНИЙ ЗЭЭЛИЙН
ӨР, ОРЛОГЫН ХАРЬЦААГ
70 ХУВИАР ТОГТООХ,**

**ХУГАЦААГ 30 САР БОЛГОХ
ЗЭРЭГ ШИЙДВЭРИЙГ
ГАРГАСАН. БОДЛОГЫН
ШИЙДВЭРИЙН ИРЭЭДҮЙД
АВЧРАХ ҮР ДҮН, АЧ
ХОЛБОГДЛЫГ ТА ХЭРХЭН
ХАРЖ БАЙГАА ВЭ?**

Дэлхийн банкны зүгээс төв банкны эдгээр алхмуудыг бодлогын түвшинд дэмжиж байгаа. Гэхдээ хэрэгжих хугацааны хувьд арай хожуу байна уу гэж бодож байна. Мэдээж шинэ бодлогын шийдвэр гарахад эдийн засагт оролцож байгаа хүмүүс, аж ахуй нэгжүүд дасан, зохицох хугацаа хэрэгтэй. Гэхдээ гадаад сектор, төлбөрийн тэнцэл, ханшид ирж буй дарамтыг авч үзвэл хэрэгжих хугацааг нь илүү ойрхон тавьж өгсөн бол илүү үр дүнтэй байх байсан гэж харж байгаа. Сүүлийн үед банк, банк бус санхүүгийн байгууллагууд зээлийг маш ихээр идэвхтэй олгож байна. Ирэх оноос хэрэглээний зээлийг хумих бодлого явагдах гэж байгаа учраас 1 дүгээр сарын 1-нээс өмнө амжиж зээлээ аваарай гэдэг мессэж, зар сурталчилгаанууд өдөр бүр сонсож байна. Тэгэхээр макро зохистой бодлогын шийдвэрүүдийг хугацааны хувьд хурдан хэрэгжүүлэх ёстой байсан болов уу гэж харж байгаа. Төв банкнаас хамгийн сүүлд бодлогын хүүг нэмэгдүүлснийг өмнө дэмжиж байгаа. Харин ч бага зэргийн хугацааны хоцрогдолтой хүүгээ өсгөв үү ч гэж харж байгаа.

ЯАГААД?

Яагаад гэвэл үндсэндээ хоёр гол хүчин зүйл макро талдаа томоохон эрсдэл үүсгэж байна гэж хэлж болохоор байна. Нэгдүгээрт,



Б.ДАВААДАЛАЙ

Дэлхийн банкны Төсөв, Макро эдийн засгийн газрын эдийн засагчаар ажилладаг бөгөөд өмнө нь Монголбанкны Мөнгөний Бодлогын Газарт эдийн засагчаар ажиллаж байсан. Судалгааны чиглэлийн хувьд эдийн засгийн өсөлт, түүний мөчлөг, төсөв, мөнгөний бодлого, санхүүгийн зах зээлийн талаар голлон судалгаа хийж байсан туршлагатай. МУИС-ийн Эдийн засгийн сургуулийг төгссөн бөгөөд 2014 онд АНУ-ын Нью Йорк хотын Колумбын их сургуульд эдийн засгийн чиглэлээр мастерийн зэрэг хамгаалсан.

импорт өсч байна. Хоёрдугаарт, зээлийн өсөлт их байна. Энэ хоёроос шалтгаалаад манай улсын төлбөрийн тэнцэл, ханш дээр ирэх дарамт нэмэгдэж байгаа. Энэ нь ч сүүлийн үед нэлээд тод ажиглагдах болсон. Гадаад зах зээлийн зүгээс ч бас ханш сулрах дарамт өндөр байна. АНУ-ын Төв банк хүүгээ өсгөсөн. Энэ нь хөгжиж байгаа орнууд руу орж ирэх хөрөнгийн урсгалыг мэдээж бууруулж байгаа. Мөн ам.доллар өөрөө дэлхийн ихэнх орны валютын эсрэг чангарч байна. Манайхаас хамаарахгүйгээр худалдааны дайны нөлөө дэлхийн эдийн засагт нөлөөлж эхэлж байна. Ялангуяа, түүхий эдийн зах түүн дотроо зэсийн үнэ хэдэн сарын өмнө огцом буурахад хүргэсэн. Гэх мэтээр Монгол руу орж ирэх валютын урсгалд сөрөг нөлөө гарах эрсдэлүүд ажиглагдсан. Дээрээс нь дотооддоо импорт өссөн, зээлийн өсөлт өндөр байсан. Мөн улс төрийн тогтворгүй байдал ч нөлөөлсөн. Үүнээс болоод төгрөгийн ханш есдүгээр сараас хойш хэд хэдэн удаа нэлээд огцом суларлаа. Тэгэхээр төв банкны хувьд ханшийг хэт чөлөөтэй, эсвэл хэт тогтвортой байлгах гэхээсээ илүү аль болох аж ахуйн нэгжүүдэд сөрөг нөлөө багатай, валютын нөөцдөө мөн өндөр дарамтгүй, макро эдийн засгийн хувьд аль болох сөрөг нөлөө багатай байх зөв тэнцвэрийг олох нь чухал байх. Гэхдээ бидний өгч байгаа гол зөвлөмж бол төв банк аль болох олон нийттэй харилцах сувгаараа дамжуулан ханшийн талаар мэдээллийг илүү сайн өгч, хүлээлтийг удирдах тал

илүү ажиллаж чадвал чухал байна. Яагаад гэвэл төв банк ханшийг байнга бариад байж чадахгүй шүү дээ. Ер нь ханшийг аль болох хөвөгч дэглэм рүү алгуур шилжүүлэх хэрэгтэй. Үүний тулд олон нийттэй харилцах, хүлээлтийг удирдах нь хамгийн чухал суваг байх боломжтой. Тэгэхгүй бол бид ханшаа хамгаалах гэж хичээгээд, ямар их хэмжээний нөөц, зардал гарсныг өнгөрсөн жилүүд бидэнд сануулдаг. Гашуун сургамжийг авсан шүү дээ.

ХЭДИЙГЭЭР ЭДИЙН ЗАСАГТ САЙН ҮР ДҮН ХАРАГДАЖ БАЙГАА Ч 2019 ОНООС ЭРГЭЭД ТОДОРХОЙ ЭРСДЭЛҮҮД БИЙ БОЛЖ БОЛЗОШГУЙ БАЙГААГ СУДЛААЧИД ОНЦОЛЖ БАЙГАА. ЯЛАНГУЯА ГАДААД ОРЧИН ТАЛААС ТОДОРХОЙ БУС БАЙДАЛ НЭМЭГДЭЖ БАЙГАА НӨХЦӨЛД ТӨВ БАНКНЫ БОДЛОГО АЛЬ ЧИГЛЭЛД ХЭРЭГЖИХ НЬ ЭРСДЭЛИЙГ БУУРУУЛАХАД ТҮЛХЭЦ ҮЗҮҮЛЭХ БОЛ?

-Хамгийн эхэнд төв банкны тухайд үнийн тогтвортой байдал чухал. Инфляцийг яаж зорилтот түвшинд хадгалах вэ гэдэг гол асуудал. Сүүлийн хэдэн жилийн хугацаанд 8 хувьд тогтворжуулахыг зорьж байгаа. 2018 оны тухайд инфляци харьцангуй зорилтот түвшинд байлаа. Харин 2019 оны тухайд бидний зүгээс инфляцийг маш анхааралтай ажиглах хэрэгтэй гэж төв банкинд зөвлөж байгаа. Энд эрсдэл үүсч эхэлж байна. Энэ оны 11 дүгээр сарын байдлаар

инфляци улсын хэмжээнд 8.1 хувь, Улаанбаатар хотын хэмжээнд 9 хувийг давсан. Төв банкны мэдээлж байгаагаар инфляцийн дийлэнх нь нийлүүлэлтийн гаралтай бүтээгдэхүүний үнийн өсөлтөөр тайлбарлагдаж байгаа. Эрэлтийн гаралтай инфляци бага байгаа хэдий ч эмпирик судалгаануудаас харахад эхлээд нийлүүлэлтийн гаралтай буюу шатахуун, түлш, нүүрсний үнэ өсөх нь хоёр, гурван сарын дараа, эсвэл маш богино хугацаанд бусад бараа, бүтээгдэхүүний үнийг өсгөдөг. Эргээд бусад бүтээгдэхүүнд маш хурдан шингэдэг гэсэн үг. Тэгэхээр энэ нөлөөг тооцоод, 2019 онд төв банкны анхаарах гол зүйл инфляци гэж бид үзэж байгаа. Өнөөдрийг хүртэл эрсдэл бага байсан ч цаашид инфляци өсөх эрсдэл өндөр байна. Мэдээж мэргэжлийн байгууллага энэ асуудлыг сайн харж, анхаарч байгаа байх. Хоёрдугаарт, банкны зээл, импортыг яаж хязгаарлах вэ гэдэг асуудал. Макро зохистой бодлогын арга хэрэгслүүд, мөн бодлогын хүүг өсгөхөөс гадна өөр ямар шийдлүүд байж болох вэ. Энэ асуудалд онцгой анхаарч, ханш дээр ирэх дарамтыг бууруулахын сацуу валютын нөөцөө зохистой түвшинд хадгалах нь төв банкны хувьд анхаарах ёстой голлох асуудал байх болов уу. Гадаад эдийн засгийн орчинд тодорхой бус байдал их байна. Хамгийн гол нь түүхий эдийн үнэ ирэх онуудад буурах хүлээлттэй байна. Ийм хүлээлттэй байгаа орчинд төв банк аль болох алгуур, болгоомжтой, үнийн тогтвортой байдлыг хадгалсан, төсвийн бодлоготойгоо маш сайн уялдаатай

бодлогыг хэрэгжүүлэх хэрэгтэй.


2019 ОНД ТӨСӨВ НЭЛЭЭД ТЭЛЖ БАЙГАА ШҮҮ ДЭЭ. ЭНЭ НӨХЦӨЛД МӨНГӨНИЙ БОДЛОГО ТАЛААС ОРОН ЗАЙ ХУМИГДАХ НЬ ГЭЖ ҮЗЭЖ БАЙГАА?


-2017, 2018 онд эдийн засагт тохиргоо хийх хөтөлбөрийн нөлөөгөөр төсвийн зардал харьцангуй дүнгээрээ төдийлөн нэмэгдээгүй. Харин 2019 онд зардал нэлээд өссөн. Ялангуяа, хөрөнгө оруулалт тал дээр нэлээд хэмжээгээр нэмэгдэж байгаа. Төсвийн хөрөнгө оруулалт нэмэгдэнэ гэдгийг эмпирик судалгаа болон түүхэн тоон мэдээллүүдэд үндэслэж харахад ч тэр импортыг ихээр нэмэгдүүлдэг. Импорт нэмэгдээд эхлэхээр төв банкны хувьд ханшаа тогтворжуулах, ханш дээр ирэх дарамт нэмэгдэнэ. Энэ тохиолдолд аль болох мөнгөний бодлогын орон зайгаа хадгалж, бодлогоо хэрэгжүүлэх нь чухал. Нэг талаас төсвийн зардлаар дамжиж, эдийн засагт нэлээд тэлэлт явагдах нь. Нөгөө талдаа мөнгөний бодлогоор төсвийн тэлэлтийг аль болох зөөлрүүлэх, шаардлагатай тохиолдолд мөнгөний бодлогыг хатууруулах чиглэлд ажиллах нь зүйтэй болов уу. Дээрээс нь улс төрийн эрсдэл байна. 2020 онд сонгууль болно. 2019 он бол сонгуулийн өмнөх жил. Сүүлийн үед гарсан ЖДҮ-ийн асуудалтай холбоотой эрсдэлүүд байна. Энэ асуудлыг олон улсын байгууллагууд, гадны хөрөнгө оруулагчид маш анхааралтай ажиглаж байна. Гуравдугаарт,

уул уурхайн салбарт хэрэгжихээр төлөвлөөд байгаа, томоохон төслүүдийн хэрэгжилтийн асуудал бий. Хэрэгжихээр төлөвлөсөн хугацаандаа, зөв зохистойгоор хэрэгжих үү, үгүй юу гэдэг асуудал маш их анхаарал татаж байна. Тавантолгой, Оюутолгой зэрэг томоохон төслүүдэд хэр ахиц гарах вэ. Бусад томоохон төслүүдийн үйл ажиллагаа эдийн засгийн ирээдүйн төлөвт маш чухал нөлөөтэй. Үүнээс гадна нэмж хэлэхэд 2019-20 он бол Монголын эдийн засгийн хувьд маш чухал жил. Яагаад гэвэл 2021 оноос эхлээд бид дахиад том төлбөрүүд хийгдэж эхэлнэ. Тэгэхээр 2019 онд маш хянамгай байж, асуудлаа зөв шийдэж, бэлтгэлээ базааж авахгүй бол бид эргээд 2017 оных шиг дефолт зарлах түвшинд ирэх эрсдэл ч ирж болзошгүйг мартаж өгсгүй. Эдийн засаг сэргэж байгаа нь үнэн. Гэхдээ суурь асуудлууд хэвээрээ л байна. Экспортын орлого тодорхой хэдхэн бүтээгдэхүүнээс хамааралтай хэвээр байна. Эдийн засаг төрөлжөөгүй, орлого олох орон зай маш бага байна. Хил дээр багахан асуудал үүсэхэд л бүх зүйл шат дараатайгаар нурах аюултай хэвээр байна. Тэгэхээр эдийн засгийн дархлаагаа сайжруулж, удахгүй төлөгдөх том төлбөрүүдэд бэлтгэлтэй байх нь хамгийн чухал болоод байна. Засгийн газрын түвшинд ч тэр, төв банкны түвшинд ч тэр бодлогын уялдаатай байж, зохистой бодлого хэрэгжүүлэхгүй бол эдийн засаг эргээд ихээхэн хүндрэлд орох эрсдэл маш ойрхон гэдгийг санах хэрэгтэй.

ЯРИЛЦАНД БАЯРЛАЛАА.

**ТҮҮХИЙ ЭДИЙН ДЭЛХИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ҮНЭ
(АМ.ДОЛЛАРААР, 24/ХИ ӨДРИЙН БАЙДЛААР)**





ПОЛ ВОЛКЕРИЙН ӨВ

Өнөө цагт Төв банкны мөнгөний бодлого нь эдийн засгийн хамгийн хүчтэй хөдөлгөгч хүчний нэг, үнийн тогтвортой байдлыг хангах үндсэн арга хэрэгсэл болж өргөжөөд байна. Тиймээс Төв банкны тэргүүнүүдийн хэлсэн үг бүр жин дааж, зах зээлд оролцогч бүр анхааралтай ажигладаг болсон. Тэгвэл Төв банкны мөнгөний бодлогын ач холбогдлыг нэмэгдүүлж, үнийн тогтвортой байдлыг хангахад хамгийн нөлөөтэй зүйл болохыг дэлхийн тэргүүлэх эдийн засаг дээр нотлон харуулж чадсан тэрхүү эрхмийг “Монголбанкны мэдээлэл” товхимлоор онцлон бичиж байна. Тэр бол Пол Волкер бөгөөд эдийн засагчдын дунд домог болж, олон нийтийн дунд алдаршсан нэгэн

билээ. Тэрбээр 1979-1987 онд АНУ-ын Холбооны нөөцийн төв банкны тэргүүнээр ажиллаж байсан бөгөөд тухайн үед АНУ-н эдийн засагт нүүрлээд байсан өндөр инфляцийг хазаарлаж чадсан гавьяатай.

Өдгөө 91 нас зооглож буй алдарт эдийн засагч өнөөг хүртэл сургаалаа айлдсаар байна. Дөнгөж саяхан Пол Волкер өөрийн “Цуцашгүй гүйцэтгэл: Үр нөлөө бүхий мөнгөний бодлого ба сайн засгийн газрын эрэлд” нэртэй намтраа хэвлүүлж гаргасан нь энэ онд уншвал зохих номны жагсаалтад орлоо. Товчхондоо бол тэрбээр намтартаа хэрхэн мөнгөний бодлогын үр нөлөөг нэмэгдүүлж, “биелэгдэшгүй даалгавар” болох үнийн тогтвортой байдлыг хангаж чадсанаа дурдахын

сацуу өнөөгийн хэт зөөлөн буюу уламжлалт бус мөнгөний бодлогын талаар шүүмжээ илэрхийлсэн аж.

ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТ БА ИНФЛЯЦИ

Жимми Картерийг АНУ-ын Ерөнхийлөгч байх үед буюу 1970-аас 1980-аад оны эхэнд тус улсын эдийн засаг хямарч, инфляци хоёр оронтой болж өсөв. Үнийн өндөр өсөлтийг Төв банк удирдаж чадахгүй гэсэн эдийн засагчдын шүүмжлэлийн шуурган дунд Пол Волкер 1979 оны 8-р сард Төв банкны тэргүүнээр томилогдсон бөгөөд жил гаруйн хугацаанд бодлогын хүүг 11.0%-аас 20.0% болгож өсгөсөн байна. Кейнсийн онолыг дагагч эдийн засагчид инфляцийг багасгах зорилготойгоор мөнгөний бодлогыг чангаруулах нь эргээд эдийн засгийг гүн хямралд оруулна гэж үздэг байсан бол

зарим эдийн засагчид мөнгөний бодлого биш харин эдийн засгийн суурь асуудлуудыг хөндөж байж сая инфляцийг бууруулна гэжээ. Харин бусад эдийн засагчид мөнгөний бодлогоос илүү олон нийтийн ирээдүй рүү чигэлсэн хүлээлтийг зөв удирдах замаар инфляцийг барих боломжтой гэцгээж байв. Мөнгөний бодлогын ач холбогдлыг төдий л үнэлдэггүй цаг үе байжээ.

Энэ үед Пол Волкерийн удирдлага доор Холбооны нөөцийн төв банк бодлогын хүүг чангаруулж, мөнгөний нийлүүлэлтийг хумих замаар инфляцийг бууруулж, эдийн засагчдын шүүмжлэлийг няцааж, мөнгөний бодлогын ач холбогдлыг харуулж чадсан. Цаашлаад

Кейнсийн онолыг дагагч эдийн засагчид бодлогын хүүг бууруулах нь эдийн засгийг хямралд хүргэнэ гэж үзэж байсан ч мөнгөний нийлүүлэлтийг бууруулах үед эдийн засгийн өсөлт төсөөлж байснаас бага хэмжээнд буурч, ажилгүйдлийн төвшин төдийлөн нэмэгдээгүй байна. Харин ч эсрэгээрээ Пол Волкерийн ачаар олон нийтийн Төв банкинд итгэх итгэл нэмэгдэж, үнийн өсөлтийн хүлээлтийг давхар бууруулж, үйлдвэрчний эвлэлийн цалин нэмэгдүүлэх шаардлагыг зөөлрүүлж, аж ахуй нэгжүүдийн бүтээгдэхүүн, үйлчилгээнийхээ үнийг өсгөх хандлагыг багасгасан байна. Өөрөөр хэлбэл бодлогын хүү гэсэн чухал арга хэрэгслийн үр нөлөөг нийгэмд таниулахаас гадна,


Төв банкинд итгэх олон нийтийн итгэлийг хүчтэй нэмэгдүүлсэн юм.

Инфляцийн эсрэг тэмцэж байх эхэн үед Пол Волкер бодлогын хүүг биш мөнгөний нийлүүлэлтийн өсөлтийн хурдыг удирдах гэж оролдсон боловч эцэст нь арга барилаа өөрчилсөн юм. Тэрбээр энэхүү арга барилын өөрчлөлтөө засгийн газрын, тодруулбал, Жимми Картерийн дараа АНУ-ын Ерөнхийлөгч болсон Роналд Рейганий үйлдвэрчний эвлэлийг хэт дэмжсэн бодлого болон төсвийн алдагдлын сөрөг нөлөө гэж үзсэн. Ингэснээр тэр мөнгөний бодлогын гол хэрэгслүүдийн нэг болох бодлогын хүүг ашиглаж эхэлсэн байна.

СОНГОГДСОН НЭГЭН

Пол Волкер нь АНУ-ын Нью Жерси мужид Герман гаралтай гэр бүлд төржээ. Тэрбээр бакалаврын зэргээ Принстоны их сургуулиас, магистрын зэргээ Харвардын их сургуулиас хүртсэн бөгөөд эдийн засгийн нөр их судалгаа шинжилгээ хийж байсан ч докторын зэргээ хамгаалалгүй орхисон байдаг. Гэсэн ч тэрбээр академик хэлэлцүүлэг, мэтгэлцээнүүдэд оролцох дуртай бөгөөд докторын зэргээ хамгаалж чадаагүй шалтгаанаа юмыг хойшлуулдаг хандлагатайгаа холбож тайлбарлажээ.

Тэрбээр ажлын гараагаа Холбооны нөөцийн төв банкнаас эхэлсэн ба Чейз Манхэттен банк, АНУ-ын Сангийн яаманд ажиллаж байгаад Холбооны нөөцийн төв банкны тэргүүнээр томилогдсон



THE QUEST FOR SOUND MONEY

AND GOOD GOVERNMENT

PAUL A. VOLCKER

байдаг. Түүний карьерт эргэлт авчирсан зүйл бол яах аргагүй “Алтан стандарт”-ыг халсан явдал юм. Учир нь Никсоны засаг захиргааны үед Пол АНУ-ын Төрийн департамент, Сангийн яамны Мөнгөний асуудал эрхэлсэн нарийн бичгийн даргын албыг хашиж байсны хувьд Бреттон Вүүдсийн тогтолцоо нурж унах үед дотоодын болон гадаадын гол зохицуулагчдын нэг болж хувирсан. Энэ үед тэрбээр ямар чадалтай эдийн засагч, хэлэлцээр хийгч, удирдагч болохоо харуулж Нью Йоркийн Нөөцийн банкны Ерөнхийлөгчөөр томилогдсон.

Волкер инфляцид таагүй хандах хандлага нь эдийн засгийн моральтай шууд холбоотой. Тэрбээр мөнгөний бодлогын гол үүрэг нь үндэсний мөнгөн тэмдэгтийн нэр хүнд, түүнд итгэх байдлыг хадгалахад оршино гэж үздэг. Цаашлаад эдийн засагчид сүүлийн үед инфляци хэт бага байгаа учир зорилтот төвшин хүртэл “Өсгөх хэрэгтэй” гэж хэлдгийг төдий л таашаадаггүй байна.

ТӨВ БАНКУУДЫН БОДЛОГЫН ЧИГ ХАНДЛАГЫН ӨӨРЧЛӨЛТ

Пол Волкер бодлогын хүүг огцом өсгөснөөр зарим салбарт хөрөнгө оруулалт татарсан боловч хохирол нь төсөөлж байснаас бага байж, инфляцийг бууруулж чадсанаар мөнгөний бодлогын хувьд шинэ эрин эхэлсэн юм. Төв банкнууд

урт хугацаанд инфляцийг зоригтой онилж, бодлогын хэрэгслээр дамжуулж эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангах боломжтой болсон. Төв банкуудын эн тэргүүний зорилтыг үнийн тогтвортой байдал гэж тодорхойлж, түүнийг хийж чадна гэж итгэл хүлээлгэсэнээр, инфляцийн хүлээлтийг ч мөнгөний бодлогоор дамжуулж удирдах боломжтой болжээ. Мөн инфляцийг эерэг боловч бага төвшинд хадгалах замаар мөнгөний бодлогоо хэрэгжүүлэх нь эдийн засгийн тогтвортой байдлыг бий болгох давуу талтайг харуулсан билээ.

Гэхдээ Пол Волкер сүүлийн жилүүдэд дэлхийн Төв банкуудаас хэрэгжүүлж байгаа уламжлалт бус, хэт зөөлөн мөнгөний бодлогыг ихээхэн шүүмжилж, цаашдын орон зайг үгүй хийж байгааг анхааруулсаар байна. Учир нь эдийн засаг уналтад орох үед эдийн засагчид мөнгөний бодлогыг зөөлрүүлэх замаар инфляцийг өсгөж, эдийн засгийг тэтгэхийг эрмэлздэг бөгөөд үр төлөөсөнд нь инфляци зорилтот төвшнөөсөө давах үед Төв банканд итгэх олон нийтийн итгэл суларч, мөнгөний бодлогын цаашдын өр нөлөө буурдаг байна.

Төв банканд итгэх итгэл болон инфляцийн эсрэг хамаарал инфляци өсөхөд хүчтэй мэдрэгддэг боловч буурах үед сулардаг байна.

Үүнийг 2008 оны хямралаас харах боломжтой бөгөөд инфляци зарим улсад хасах утгатай буюу дефляцитай болох үед ч иргэдийн мөнгөний бодлогод итгэх итгэл инфляцийн зорилт хэтэрсэн шиг хүчтэй буураагүй аж.

Энэ эрхмийн хэлсэнчлэн, мөнгөний бодлогын гол зорилго нь үндэсний мөнгөн тэмдэгтэд итгэх итгэлийг хадгалах юм. Яагаад гэвэл, үндэсний мөнгөн тэмдэгт жил бүр үнэ цэнээ алдах нь эдийн засагт сөргөөр нөлөөлдөг бөгөөд олон нийтийн итгэх итгэл суларч улмаар Төв банкууд инфляцийн эсрэг 1970-аад оны сүүлээр хийсэн дайныг дахин давтах шаардлага гарах вий гэж анхааруулж байна. Засгийн газар ялихгүй бага хэмжээний инфляцийн өсөлтийг хүлээн зөвшөөрөх төдийд зах зээл дээр бараа бүтээгдэхүүний үнийг өсгөх нөлөө үзүүлдгийг санах хэрэгтэй. Тиймээс, инфляци огцом өсөх нь эдийн засаг дахь маш олон эрсдэлийг бий болгодог бөгөөд төсвийн болон мөнгөний бодлогын зөв хослолын үр дүнд нам дор, тогтвортой төвшинд хадгалагдах боломжтой юм.

Тоймлосон: Б.Хонгорзул

Эх сурвалж: <https://www.economist.com/finance-and-economics/2018/12/01/paul-volckers-memoir-invites-a-rethink-of-the-fight-against-inflation>

ИНФЛЯЦИ ГЭЖ ЮУ ВЭ?

1. ҮНИЙН ӨСӨЛТ БА АМЬЖИРГААНЫ ӨРТГИЙН УЯЛДАА ХОЛБОО

Инфляци: Үнийн ерөнхий түвшний өсөлтийг харуулсан үзүүлэлт юм.

Инфляцийг бид хялбараар бараа, үйлчилгээний үнийн өсөлт, мөнгөний худалдан авах чадварын бууралт гэж ойлгож болно.

Зураг 1. Инфляци



Хэрэв инфляцгүй байвал юмны үнэ өөрчлөгдөхгүй. Гэтэл инфляц өсөхөд мөнгөний худалдан авах чадвар буурч, барааны үнэ өсдөг. Жишээ нь: "Атар" талхны үнэ 1990 онд 1.2 төгрөг байсан бол 2018 онд 1320 төгрөг болж 1100 дахин өссөн байхад, мөнгөний худалдан авах чадвар харин урвуугаар 1100 дахин буурчээ

Зураг 2. Талхны үнийн өсөлт



Гэхдээ инфляцийг зөвхөн нэг барааны үнийн өсөлтөөр биш нийт бараа, үйлчилгээний үнийн дундаж түвшний өсөлтөөр хэмжинэ. Бүх бараа, үйлчилгээний үнийн өөрчлөлтийг улсын хэмжээгээр нэг бүрчлэн хэмжих боломжгүй. Иймээс хүн амын өргөн хэрэглээний гол нэрийн бараа, үйлчилгээг сонгон авч, тэдгээрийн үнийн дундаж өөрчлөлтийг тооцдог. Сонгон авсан эдгээр бараа, үйлчилгээг САГСНЫ БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭ гэнэ.

Сагсны бараа, үйлчилгээ: Айл өрхийн бүх хэрэглээг төлөөлж чадах өргөн хэрэглээний бараа, үйлчилгээний нэр төрлийн багцыг хэлнэ. Хэрэглээний сагсны бүтцийг айл өрхүүдийн хэрэглээ, түүний хэв маягт судалгаа хийсний үндсэн дээр тодорхойлдог. МУ-ын хэрэглээний сагс нийт 12 бүлгийн 373 бараа, үйлчилгээнээс бүрдэж байна.

ИНФЛЯЦИЙГ ЗӨВХӨН ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН ХОРОО ТООЦНО.

Дээрх нэр төрлийн бараа, үйлчилгээний үнийн дундаж өсөлтөөр инфляцийг хэмжинэ. Хэрэв зах зээл дээр бараа, үйлчилгээний үнэ өсөөд байвал иргэдийн амьдралд муугаар нөлөөлдөг.

2. ИНФЛЯЦИ ХАДГАЛАМЖИНД НӨЛӨӨЛӨХ НЬ

Инфляци мөн иргэдийн хуримтлал, хадгаламжид сөргөөр нөлөөлнө. Инфляцийн түвшний өсөлт хадгаламжийн хүүний өсөлтөөс давсан тохиолдолд иргэдийн хадгаламж үнэгүйдэж эхэлдэг. Хадгаламж төдийгүй бусдад бэлэн мөнгө зээлдүүлсэн тохиолдолд мөн адил үр дагаврыг авчирна.

3. ИНФЛЯЦИ БАЙХ ШААРДЛАГАТАЙ ЮУ?

Үнэ буурах нь бизнес эрхлэгчдэд сөрөг нөлөөтэй байдаг, учир нь ирээдүйн зарах бүтээгдэхүүнийх нь үнэ нэмэгдэхгүй. Энэ нь ажиллагчдынхаа цалин өсөхгүй, эсвэл урамшуулал олгохгүй гэсэн үг юм. Ингэснээр ажиллагчид хөдөлмөрлөх сонирхолгүй болох, бүтээмж, үйлдвэрлэл буурахад нөлөөлнө.

Инфляци өндөр байх нь иргэдийн амьдралын түвшин буурах, цалин нэмэгдсэн ч улмаар үйлдвэрлэл буурах, татвар нэмэгдэхэд түлхэц өгөх аюултай.

Үнэ урт хугацаанд нам тогтвортой хэмжээнд өсөх нь хамгийн зохистой. Хөгжиж байгаа улсын хувьд инфляци 5-8 хувь өсөх нь хамгийн зохистой байдаг.

4. ҮНЭ ТОГТВОРТОЙ БАЙХЫН АЧ ХОЛБОГДОЛ

Инфляци нь эдийн засгийн өсөлт, ядуурал гэх мэт шиг үргэлж олны анхаарлын төвд байдаг сэдэв биш бөгөөд үнэ тогтвортой үед "мартагддаг" гэж хэлж болохоор үзүүлэлт. Харин үнэ тогтвортой байхаа больсон цагт л бид ямар нэг явдал үүсэхийн урьдач дохио ирснийг гэнэт ухаарах нь түгээмэл.

Үнэ тогтвортой байна гэдэг нь нийт ард иргэдэд ашигтай зүйл бөгөөд эдийн засаг тогтвортой, үр ашигтай ажиллах суурь хөрс болдог. Учир нь бүтээгдэхүүн, үйлчилгээний үнийн өөрчлөлт бол худалдан авч буй хэрэглэгчид, мөнгөө хадгалуулж буй хадгаламж эзэмшигчид, эсвэл хөрөнгө оруулалт хийж буй бизнесийн байгууллагууд гээд хэн бүхэнд шууд нөлөөтэй. Харин үнэ тогтворгүй үед иргэдийн бодит орлого буурах, ядуурал нэмэгдэх, нийгэмд тэгш бус байдал даамжрах г.м. олон сөрөг үр дагавар бий болдог.

2018 ОНД 22 ТОНН АЛТ ХУДАЛДАН АВЛАА

Монголбанк 2018 оны 12 дугаар сард 2.9 тонн алт худалдан авсан нь өмнөх оны мөн үед 0.9 тонн алт худалдан авч байснаас 2.0 тонн илүү буюу 221%-иар /2 дахин/ өссөн үзүүлэлттэй байна.

Харин Монголбанк 2018 онд 22 тонн алт худалдан авсан нь 2017 онд 20 тонн алт худалдан авч байснаас 2 тонноор илүү буюу 9.3%-иар өссөн үзүүлэлт болов.

2018 оны 10 дугаар сарын 15-ны өдрөөс 12 дугаар сарын 31-ний өдрийг дуустал хугацаанд Дархан-Уул аймаг дахь Монголбанкны хэлтэс 142.2 кг алт, Баянхонгор аймаг дахь Монголбанкны салбар 79.6 кг алтыг худалдаж авсан үзүүлэлттэй байна.

2018 оны 12 дугаар сарын туршид 1 грамм алт худалдан авах Монголбанкны дундаж үнэ 105,616.35 төгрөг байлаа.

График 1. 2000-2018 онд Монголбанкны худалдан авсан алтны хэмжээ






График 2. 2018 оны 12 дугаар сард Монголбанкны алт худалдан авсан үнэ



ВАЛЮТ АРИЛЖААНЫ ЦАХИМ ТАЛБАРЫН АРИЛЖААНЫ ТОЙМ

БХВАЦТ-ыг 2017/4/10-нд нэвтрүүлснээс хойш 2018/12/25-ний хооронд 703,8 сая ам.долларын болон 112.4 сая юанийн нийт 928 удаагийн арилжаа БХВАЦТ-т хийгдээд байна.



Options

Amount: 0.1

Low	Total	Amount	Bid	Ask
	0.1	0.1	2421.500	2421.500
	0.3	0.1	2423.000	2423.000
	0.6	0.5	2420.500	2420.500
	1.4	0.8	2420.000	2423.000
	2.4	1.0	2416.000	2424.000

Col: P. 10 Time: City: Pair: Side: Amount: 0.000 Date: Agt: Rate: Open: Total: Type: TF: 00

624 0PM 16:24 Luxor Precision 10 Net 301.2x Yuan VS 199.2x Yuan Year Ago

623 0AM 16:24 Hartford Dividend and Growth Addl IBM, Exits Investors, Co's Inc

622 5PM 16:24 How Good are Richmond, really?

What's your rank?

“Хүн нэг өглөө босоод л санхүүгийн мэдлэгтэй болдоггүй”

Шон мэнди
(Дэлхийн банкны зөвлөх)





ТӨСӨВЧИН Аппликэйшн



Энэхүү аппликэйшн нь өөртөө хуримтлал тооцоологч, хадгалагч, зээл тооцоологч, ипотек, төсөвлөгч зэрэг тооцоолууруудыг багтаасан.


www.sankhuuginbolovsrol.mn





 /Mongolbank.mn


 /Mongolbankmn

 /Санхүүгийн боловсрол

 info@mongolbank.mn

 @mongolbank_mn

 11 310081

 www.mongolbank.mn